



БОЛОВСРОЛ
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



From
the People of Japan



Save the Children
セーブ・ザ・チルドレン

“НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР” СУРГАЛТЫН МОДУЛЬ

(3 дахь хэвлэл)

- Боловсруулсан:** Н.Нарантуяа (БХАН-ийн “Сургууль, Багшийн Хөгжил”
Хөтөлбөрийн менежер)
Д.Энхтуяа (БХАН-ийн сургагч багш)
Х.Батхүү (БХАН-ийн сургагч багш)
- Хянасан:** Ж.Мягмар (БСШУСЯ-ны СӨБХэлтсийн дарга)
Р.Балжинням (БСШУЯ-ны БХЗГазрын мэргэжилтэн)
Ц.Оюунтунгалаг (Японы Хүүхдийг Ивээх Сангийн Төслийн
ажилтан)

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Японы Хүүхдийг Ивээх Сан нь (ЯХИС) хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүнлэгийн, ашгийн бус олон улсын төрийн бус байгууллага юм.

ЯХИС-ийн Монгол дахь Хөтөлбөр нь Японы Гадаад Харилцааны Яамны санхүүжилтээр “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг 2015 оны 3 дугаар сараас эхлэн 3 жилийн хугацаанд Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 24 сургууль дээр хэрэгжүүлж байна.

Төслийн зорилтууд:

1. Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар бага ангийн багш нарын мэдлэг, ойлголт, чадварыг сургалтад хамруулах замаар дээшлүүлэх
2. Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжих ялангуяа сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдэд сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах сургуулийн бүтэц, тогтолцоо бүрдүүлэх
3. Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх/ асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах
4. Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах

Төслийн хүрээнд сургуулийн удирдлага, багш, ажилтнууд, эцэг эхчүүдэд зориулсан дараах 5 төрлийн сургалтын модулийг боловсруулан зорилтот сургуулиудад хэрэгжүүлж байна. Үүнд:

1. “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-16 цаг (2 өдөр)
2. “Хүүхдийн хувийн мэдээллийн цуглуулж, ашиглах арга зүй-8 цаг (1 өдөр)
3. “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”- 16 цаг (2 өдөр)
4. “Эцэг эх- Багштай харилцах дэвтэртэй ажиллах арга зүй”-24 цаг (3 өдөр)
5. “Сургууль- Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй”-16 цаг (2 өдөр)

“НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР”

СУРГАЛТЫН МОДУЛЬ

(3 дахь хэвлэл)

Тус номыг “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

@ Зохиогчийн зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.



Товчилсон үгийн тайлбар

БХАН-Боловсролын Хамтын Ажиллагааны нийгэмлэг

БСШУСЯ-Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын яам

ДЗСЧСХ-Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр

СЭЭХ-Сургуулийн эцэг эхийн холбоо

СЭЭЗ-Сургуулийн эцэг эхийн зөвлөл



АГУУЛГА

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БҮЛЭГ 1. “СУРГУУЛЬ НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”

- 1.1. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох,
суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого,
үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх нь7

БҮЛЭГ 2. “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР”

- 2.1. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох,
суралцах чадварыг дэмжих хөтөлбөрийн тухай ойлголт 14
- 2.2. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох,
суралцах чадварыг дэмжих хөтөлбөрийн бүрэлдэхүүн
хэсгүүдийн талаарх ойлголт, хэрэгжүүлэх арга замууд 16

БҮЛЭГ 3. “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

- 3.1 Сургуулийн удирдлага, багш, ажилтнууд,
хамтрагч байгууллагуудыг төлөвлөлт хэрэгжилтийн
үйл ажиллагаанд оролцуулах нь38
- 3.2 Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох,
суралцах чадварыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөлт,
хяналт үнэлгээ хийх нь 41

ХАВСРАЛТ

- Сургуулийн өөрийн үнэлгээний хуудас 45
- Үнэлгээг нэгтгэх хуудас 60

НОМ ЗҮЙ63

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС64



МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Модулийн нэр	Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр
Зорилтот бүлэг	Сургуулийн удирдах болон бусад ажилтнууд
Сургалтын багц цаг	16 цаг
Танилцуулга	Энэхүү модулийг боловсруулахдаа “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийн суурь судалгааны дүгнэлт болон БХАН-ээс хэрэгжүүлдэг олон нийтийн оролцоот сургууль төслийн хүрээнд боловсруулсан агуулга, арга зүй, туршлага дээр үндэслэсэн. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хөтөлбөр, төслүүдээс гаргасан ном, гарын авлага материалуудаас тусгасан.

Нэгдүгээр ангийн сурагчдыг хүлээн авч буй сургууль бүрийн бодлого, тогтолцоо, хэрэгжүүлж буй арга зам, тэдний багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчид, ажилтнуудын мэдлэг, хамтын ажиллагааны түвшин өөр өөр байдаг. Сургууль бол бүх талын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн бодлого, удирдлагын алсын хараа, тухайн орон нутаг дахь байгууллагуудын түншлэл, харилцан үйлчилгээ сайн дурын оролцоог хангаж улмаар тасралтгүй суралцаж үнэт зүйлс соёлоо бий болгон бүтээх органик бүтэц юм. Энэхүү модульд санал болгож буй нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн бодлого, зохион байгуулалтын загварыг өөрийн сургуулийн онцлогтоо тохируулан өөрчилж болно. Энд хэрэгжүүлэх үйл ажиллагааг дасгал хэлбэрээр алхамчлан боловсруулсан.

Модулийн зорилго	Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого, үйл ажиллагааг 3 бүлгийн хүрээнд төлөвлөн сурагчдын дасан зохицох, суралцах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хамтарсан үйл ажиллагаагаар дэмжих, энэхүү үйл ажиллагаанд түншлэлийг нэмэгдүүлэх, эцэг эхийн оролцоог тогтмолжуулахад чиглэсэн шинэлэг үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах, үнэлэх, туршин хэрэгжүүлэх арга зүйд удирдах ажилтан, бусад ажилтнууд суралцана.
------------------	---

Модулийн агуулгын хүрээ	Арга зүй
<p>БҮЛЭГ НЭГ: “СУРГУУЛЬ НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”</p> <p>1.1 Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх нь</p>	<p>А. Суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар</p> <p>Б. Суралцагчдад өгөх мэдээлэл (унших, харилцан ярилцах, хэлэлцэх)</p> <p>В. Үйл ажиллагаа (суралцагчдын шинэ мэдлэг, мэдээллийг техник хэрэгсэл ашиглан тайлбарлан таниулж, харилцан ярилцана. Өгсөн материалыг бие даан судална. Багаар, бүлгээр хамтран ажиллана, асуудал шийднэ, үнэлгээ дүгнэлт өгнө)</p> <p>Г. Зохион байгуулалт:</p> <ul style="list-style-type: none"> • Багаар • Багштай хамтарч



БҮЛЭГ ХОЁР: "НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР"

2.1 "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр"-ийн тухай ойлголт

2.2 "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих" хөтөлбөрийн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх арга замууд

БҮЛЭГ ГУРАВ: "НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

3.1 Сургуулийн удирдлага, багш, ажилтнууд, хамтрагч байгууллагуудыг төлөвлөлт, хэрэгжилтийн үйл ажиллагаанд оролцуулах нь

3.2 "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр"-ийн төлөвлөлт, хяналт, үнэлгээ хийх нь

Хүрэх үр дүн: Сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөгжлийн ерөнхий чиг хандлагыг тусгасан гурван бүлэг, таван дэд бүлгийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарим санаа, хамтран ажиллах төлөвлөгөө, үйл ажиллагааны загварыг санал болгоно.

Үнэлгээ дүгнэлт:
Модулийн агуулгаас шалтгаалан сургалтанд хэрэглэх материал өөр өөр байна.

Модулийн зорилгод тусгагдсан үр дүнг шалгах асуулт, даалгавар, сорил

Сургалтын хэрэглэгдэхүүн

Тараах материал, бүтээлч даалгавар, дасгалыг сургалтад ашиглана.



1 | СУРГУУЛЬ НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИЖ БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлох, ДЗСЧДСХөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон үр дүнг үнэлэхэд шалгуур үзүүлэлтийг ашиглах арга зүйгээс суралцах.

Хамрах хүрээ: Сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч, номын санч бусад ажилтнууд, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, өрхийн эмч, цэцэрлэгийн удирдлага, багш ажилтнууд

Хүрэх үр дүн: Сургуулийн өөрийн үнэлгээн дээр үндэслэн сургуулийн удирдах ажилтан болон ажилтнууд, орон нутгийн байгууллагууд хамтарсан үнэлгээ хийснээр нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж хөтөлбөр амжилттай хэрэгжих боломжтой болно.

Хэрэглэгдэхүүн: Оролцогч бүрт сургуулийн өнөөгийн байдлыг үнэлэх үнэлгээний хуудсыг олшруулан бэлтгэнэ.

Арга зүй: Оролцогчдын идэвх оролцоог нэмэгдүүлсэн, бүтээлчээр сэтгэх, хамтран ажиллах, өөрийн үнэлгээ хийх чадваруудыг дэмжсэн арга зүйг ашиглана.

1.1. НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

ДАСГАЛ: “БИ ӨӨРӨӨРӨӨ БАХАРХДАГ”

- Оролцогчид тойрог болон зогсоно.
- Оролцогчид өөрийн нэр, сургуулиа хэлж дараа нь “Би өөрийнхөө зан чанараар бахархдаг” гэсэн үнэлгээг хэлнэ.

Үүний дараа сургагч багш дараах чиглүүлгийг өгнө:

Хүн бүр, байгууллага бүхэн өөрийн үнэт зүйлс, өөрийгөө үнэлэх үнэлэмж байдгийн адил бид энэ удаад сургуулийнхаа “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжиж буй өнөөгийн байдал”-д үнэлгээ хийх юм гэж зорилгоо танилцуулна.

Сургуулийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх:

Үнэлгээг **Хавсралт 1** буюу сургуулийн өөрийн үнэлгээний хуудсыг ашиглан хийнэ.

Үнэлгээг хийхийн өмнө сургагч багш эсвэл чиглүүлэгч дараах чиглүүлэг, зөвлөмж, сануулгыг үнэлгээнд оролцогчдод тайлбарлан таниулна.



"Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжиж буй өнөөгийн байдал"-даа үнэлгээ хийх зөвлөмж

- **Уур амьсгал.** Энэхүү үнэлгээ нь "Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжиж буй өнөөгийн байдал"-даа үнэлгээ хийж сургуулийн бодлого, үйл ажиллагааны түвшинг тодорхойлж шаардлагатай өөрчлөлт, зохион байгуулалтыг хийх зорилготой тул чин сэтгэлээсээ хандах, мөн энэ бол ямар нэг уралдаан, эсвэл шалгалт, сайн, муу гэсэн үнэлгээ биш учраас байгаа байдлаа бодитоор үнэлэхдээ санаа зовохгүй байх нь маш чухал гэдгийг тайлбарлах хэрэгтэй.
- **Дарамт шахалтгүй байх.** Үнэлгээ хийх явцад бусад нь саад хийхгүй, сатааруулахгүй байхаар зохион байгуулна. Хүн бүр өөрийн үзэл бодлоор үнэлэх боломжийг бүрдүүлэх нь чухал. Бусдын бодлыг зөв буруу гэж шүүхгүй байхыг анхааруулаарай. Хэрэв үүнийг анхаарахгүй бол үнэлгээнд оролцогчдыг биеэ барих байдалд хүргэнэ.
- **Оролцогчдод урам хайрла.** Тэвчээртэй бай. Хэрвээ асуултаа ойлгохгүй байх, дахин унших, нягтлах шаардлагатай бол тэдэнд хангалттай цаг өгөх нь чухал.
- **Оролцогчдын хичээл зүтгэлийг хүндэтгэ.** Оролцогчдыг асуултад хариулж байх үед чухал ач холбогдолтой, цаг үеэ олсон үйл ажиллагаанд оролцож байгаа гэдэг итгэл үнэмшлээр дүүрэн байлгах хэрэгтэй. Тэдний үнэлгээ хийж байгаа оролцоог дэмжин сайшаах нь чухал гэдгийг анхаараарай.
- **Таларх.** Бүх хүмүүст оролцсонд нь талархахаа мартуузай.

Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг сургуулийн удирдах ажилтан болон ажилтнууд, хамтрагчид цуглан бодитойгоор үнэлснээр энэхүү чиглэлээр баримтлах сургуулийн бодлогоо тодорхойлж, өнөөгийн түвшингээ ахиулах, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд тус дөхөмтэй. Мөн боловсруулсан хөтөлбөрөө хэрэгжүүлэх явцдаа дахин үнэлгээ хийж, дараагийн алхмаа тодорхойлж, үйл ажиллагаагаа сайжруулснаар нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого үйл ажиллагаа тогтвортой амжилттай хэрэгжих боломжтой болно.

"Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжиж буй өнөөгийн байдал"-ын үнэлгээ нь **6 багц агуулгын** хүрээнд **5 түвшнээр** үнэлэхээр боловсруулагдсан бөгөөд үнэлгээний агуулга, түвшин, үнэлэх хуудастай урьдчилан сайн танилцаж, аль болохоор бодит үнэлгээ хийх нь та бүхний цаашдын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр болно.



Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээг зохион байгуулах, үнэлгээний хуудсыг ашиглах заавар

Зорилго: "Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь " төсөлд хамрагдаж буй сургуулиудын удирдлага, багш, ажилтан, эцэг эх, хамтран ажиллагсад /өөр өөрсдийн/ сургуулийнхаа өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны хүрээг тодорхойлох

Оролцогчид: Сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч, номын санч, багш, эцэг эхийн төлөөлөл, хамтран сургах тойргийн цэцэрлэгийн эрхлэгч, багш, хорооны нийгмийн ажилтан, өрхийн эмч нарын төлөөлөл оролцоно.

Зохион байгуулалт: Үнэлгээнд оролцогчид багаар ажиллаж, тухайн сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ. Дараа нь багууд үнэлгээгээ нэгтгэн сургуулийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг санал нэгтгэйгээр гаргана. Бүлэг бүрийн үнэлгээг ярилцан, сургуулийн нөхцөл байдлын талаар нэг ойлголтонд хүрснээрээ хүн бүр ойлголтын зөрүүгээс үүдэн ялгаатай үнэлгээ өгөх эрсдлийг багасгахын зэрэгцээ өнөөгийн нөхцөл байдлын талаар ярилцсанаар цаашид төлөвлөлт хийх, аль хэсэг дээр илүү анхаарах шаардлагатай байгаа талаарх ойлголтоо нэгтгэх давуу талтай. Үнэлгээг хавсралт 1 буюу сургуулийн өөрийн үнэлгээний хуудсыг ашиглан хийнэ.

Үнэлгээ хийх хугацаа 90-120 минут байна.

Анхааруулга:

- Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг 5 түвшинд үнэлнэ.

Түвшин бүр шалгуур үзүүлэлтүүдтэй. Үүнд:

- **Гарааны түвшин** буюу **1** оноо
 - **Дунджаас доогуур түвшин** буюу **2** оноо
 - **Дундаж түвшин** буюу **3** оноо
 - **Дунджаас дээгүүр түвшин** буюу **4** оноо
 - **Үлгэр жишээ түвшин** буюу **5** оноо
- Гарааны үнэлгээнээс эхлэн шалгуур үзүүлэлтүүдтэй нэг бүрчлэн танилцана.
 - Шалгуур үзүүлэлтүүдийг уншиж, ялгааг сайн анхаарах хэрэгтэй. Учир нь түвшин ахих бүрт шалгуур үзүүлэлтүүдийн тодорхойлолт нэмэгдэж, улам нарийн болно.



Үнэлгээ хийх алхам, аргачлал:

№ Алхмууд	Үнэлгээний явц	Гарах бүтээгдэхүүн
1 Алхам 1. Үнэлгээний хуудастай танилцах	Үнэлгээ хийх 6 бүлэг, 21 шалгуур үзүүлэлт тус бүрийн 5 түвшинтэй танилцана.	Оролцогч бүр нэгдсэн ойлголттой болно.
2 Алхам 2. Шалгуур үзүүлэлт тус бүр дээр ажиллах	Гарааны түвшинээс эхлэн 5 түвшин тус бүрт өөрийн сургуулийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа үйл ажиллагааг (+), хэрэгжээгүй буюу дутмаг хэрэгжиж буй үйл ажиллагааг (-) гэж тэмдэглэнэ.	Үнэлгээний 5 түвшинээс сонголт хийхэд бэлэн болно.
3 Алхам 3. Шалгуур үзүүлэлтийн түвшинг тодорхойлох	Тухайн түвшний үйл ажиллагаануудыг тэмдэглэсэн тэмдэглэгээг харгалзан шалгуур үзүүлэлтийн түвшинг тодорхойлно.	Тухайн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ бэлэн болно.
Алхам 4. Бүлгийн түвшинг тодорхойлох	Тухайн бүлгийн бүх шалгуур үзүүлэлтийг дундажлан бүлгийн түвшинг тодорхойлно.	Бүлгийн түвшингийн үнэлгээ бэлэн болно.
5 Алхам 5. Сургуулийн түвшинг тодорхойлох	Бүлэг бүрийн түвшинг нэгтгэн, дунджийг олж сургуулийн түвшинг гаргана.	Сургуулийн ерөнхий түвшин гарна.
6 Алхам 6. Үнэлгээний түвшинг графикаар илэрхийлэх	Багаараа хамтран үнэлгээний нэгдсэн график гарган, аль бүлэгт анхаарал хандуулан ажиллах ерөнхий чиглэлийг харна.	Үнэлгээний нэгдсэн график бэлэн болно.
7 Алхам 7. Өнөөгийн үнэлгээнд тулгуурлан цаашдын чиглэлээ тодорхойлох	Үйл ажиллагааны төлөвлөлтөндөө 6 бүлэг тус бүр дээр цаашид юуг анхаарах асуудлаа тодорхойлно. Үнэлгээний үзүүлэлтүүдээс дундаж буюу дундажаас доогуур шалгуур үзүүлэлтүүдэд анхаарлаа илүү хандуулж (-) тэмдэглэгээтэй, дараагийн түвшинд чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөх хэрэгтэй.	Бодлого, төлөвлөлтөд тусгах санаа, чиглэл тодорхой болно.



Жишээ 1: Сургуулийн орчны өнөөгийн байдлыг үнэлсэн загвар

БҮЛЭГ НЭГ. СУРГУУЛИЙН БОДЛОГО

Шалгуур үзүүлэлт 1. Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох суралцах чадварыг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

Гарааны	1	2	3	4	5
	Дунджаас доогуур	Дундаж	Дунджаас дээгүүр		Үлгэр жишээ
<ul style="list-style-type: none"> Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих тухай сургуулийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг. (+) 	<ul style="list-style-type: none"> Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих бодлоготой, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг (-) Дээрх бодлого хөтөлбөрийг нэгдүгээр ангийн сурагчдын бодит хэрэгцээ, тохиолдох бэрхшээлийг тооцож боловсруулдаг. (+) 	<ul style="list-style-type: none"> Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хэрэгжүүлэхдээ сургалтын үйл ажиллагаа, багш хүний нөөц, дотоод журам зэрэг холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд тусгайлан заалт оруулж мөрдөж хэвшсэн. () 	<ul style="list-style-type: none"> Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг боловсруулж хэрэгжилтэд тогтмол хяналт үнэлгээ хийж засан сайжруулдаг, хэрэгжилтийн үр дүнг жил бүр тайлагнадаг. () Дээрх бодлогыг тодорхойлж хөтөлбөр, үйл ажиллагаа төлөвлөхөд сургуулийн багш, ажилтан, эцэг эх, хамран сургах тойргийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулж, саналыг байнга тусгадаг. () 	<ul style="list-style-type: none"> Энэхүү бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсвийн болон бусад эх үүсвэрээр шаардагдах төсөв нөөцийг бүрдүүлж, зарцуулдаг. () Сургууль нь нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох суралцах бодлого, үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг сургуулийн бодлого эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөнд баталгаажуулан тогтвортой хэрэгжүүлдэг тул тусгайлан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэггүй. () 	

- Энэ жишээний тухайд шалгуур үзүүлэлт нь (+)-ээр тэмдэглэгдсэн 1-р буюу гарааны түвшинд байна гэж тодорхойлно.
- Тухайн түвшний шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан тохиолдолд тэр түвшинд хүрсэн байна гэж үзэж оноог тавина. Хэрэв шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж чадаагүй, өөрөөр хэлбэл аль нэг үзүүлэлт нь (-) авсан байвал түвшинг доошлуулж, бүх шалгуур үзүүлэлт нь (+) тэмдэглэгдсэн түвшнээр оноогоо тэмдэглэнэ.
- Тухайн бүлгийн түвшинг шалгуур үзүүлэлт тус бүрийн онооны нийлбэрээр дундажлан гаргана. **Хавсралт 2** буюу үнэлгээг нэгтгэх хуудас
- Сургуулийн өнөөгийн байдлын түвшинг бүлэг тус бүрийн дундаж онооны нийлбэрээр дундажлан гаргана.




Жишээ 2: Үнэлгээний нэгтгэл /загвар/

д/д	Шалгуур үзүүлэлт	Түвшин				
		/1-5 хүртэлх оноогоор үнэлнэ/				
		1	2	3	4	5
		Гарааны түвшин	Дунджаас доогуур	Дундаж	Дунджаас дээгүүр	Үлгэр жишээ
1. СУРГУУЛИЙН БОДЛОГО						
1.	Шалгуур үзүүлэлт 1. Сургууль нэгдүгээр ангийн хүүхдийг сургуульд дасан зохицох суралцах чадварыг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?	1				
2.	Шалгуур үзүүлэлт 2. Сургуулийн багш бусад ажилтнууд ажил үүргийнхээ хүрээнд нэгдүгээр ангийн сурагчдыг сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагаанд оролцдог эсэх энэ талаар сургуулийн дүрэм, дотоод журам эрх зүйн бусад баримт бичигт тодорхойлж дэмждэг эсэх		2			
3.	Шалгуур үзүүлэлт 3. Сургуулийн зүгээс хүүхдийг сургуульд элсэн суралцахаас өмнө болон хичээлийн жилийн турш тэдний дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг эсэх			3		
4.	Шалгуур үзүүлэлт 4. Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан хичээлийн хуваарь, дэг хүүхдэд тохирч байгаа эсэх (завсарлагааны, хичээлийн, цайны болон чөлөөт цаг)		2			
Онооны нийлбэр		8/4				
Дундаж оноо		2 буюу дунджаас доогуур				

Энэ жишээгээр бүх үзүүлэлтүүдээ нэгтгэн гаргаад графикт оруулан өөрийн сургуулийн нэгдсэн үнэлгээ буюу ямар үзүүлэлт дээр сайн байгаа болон ямар үзүүлэлтийг цаашид хөгжүүлэх төлөвлөгөөгөө гаргахад бэлэн болно.



Жишээ 3: Сургуулийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээний 6 бүлэг тус бүрийн үзүүлэлтийг графикаар нэгтгэн харуулсан байдал



Графикаас харахад энэ сургуулийн тухайд сургалтын үйл ажиллагаа давуу, сургуулийн нийт багш ажилчдын оролцоо, орон нутгийн байгууллагуудын дэмжлэг, оролцоо дутмаг байгааг анхаарч төлөвлөх шаардлагатай нь харагдаж байна.



2 “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР”

Зорилго: “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаатай танилцана.

Хүрэх үр дүн: “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр”-ийн талаар ойлголттой болж нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголттой болж, хөтөлбөрт тусгаж болох санаа арга замуудыг олж авна.

Хэрэглэгдэхүүн:


- Сургуулийн зураглал
- Анги
- Цүнх
- “Гоё даалгавар”
- Аялалд урих
- “Дараа нь хэн байх бол? зэрэг дасгалуудад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ.

Арга зүй: Оролцогчдын идэвх оролцоог нэмэгдүүлсэн, бүтээлчээр сэтгэх, хамтран ажиллах, чадваруудыг дэмжсэн арга зүйг ашиглана.

2.1. “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Мэдээлэл: “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр” гэж юу вэ?

“Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр” нь нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжсэн сургуулийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд суралцагчийг сургуульд хүлээн авах бэлтгэл үе шатаас эхлээд хичээлийн жилийн туршид сургуулийн нийт удирдах ажилтан, ажилтнууд тодорхой үүрэг, хариуцлагатайгаар оролцож, орон нутгийн байгууллага, сургуулийн эцэг эхийн зөвлөл, эцэг, эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааг багтаасан цогц хөтөлбөр юм.



“Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр”-ийн үзэл санаа



Яагаад “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Сургуульд дасан зохицох, суралцах чадвар нь хүүхэд бүрт харилцан адилгүй байдаг тул аль болохоор богино хугацаанд сургуулийн орчинд дасан зохицуулах, суралцах чадварыг дэмжих нь энэхүү хөтөлбөрийн гол зорилго болно. Сурагчдын дасан зохицох үе шатанд тохирсон үйл ажиллагаа, суралцах чадварын ялгааг хурдан хугацаанд арилгах зорилтыг сургуулийн бодлого, төлөвлөгөөнд тусгаснаар нэгдүгээр ангийн багш төдийгүй сургуулийн бусад ажилтнууд, эцэг эхчүүд орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаа зохион байгуулах боломж бий болно.



“Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр”-нь дараах үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд суралцах сургуулийн бэлэн байдлыг хангахад
- Сургуулийн орчин нэгдүгээр ангийн сурагчдад аюулгүй, ээлтэй байхад
- Нэгдүгээр ангийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлог, суралцах арга барилд нийцсэн сургалтын хөтөлбөр, арга зүй хэрэглэхэд
- Нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих үйл ажиллагаанд сургуулийн удирдлага, ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэхэд
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролд туслалцаа дэмжлэг үзүүлэх, тэдний оролцоог дэмжин ажиллахад
- Орон нутгийн захиргаа, олон нийтийн дэмжлэгийг авч, хамтран ажиллахад

ДАСГАЛ: “МИНИЙ СУРАГЧ НАС”

Зорилго: Сурагч ахуй насаа эргэн санаж, хүүхэд сургуульдаа ирэхэд таатай болон таагүй байлгадаг байсан зүйлсийг эргэн сануулах, таагүй зүйлсийг бууруулахад сургуулийн бодлого, төлөвлөлтөд тусгах талаар ярилцах

Хэрэглэгдэхүүн: Дадлага ажлын цаас, таван өнгийн цаас, фломастер



Ажиллах алхам:

- Сурагч ахуй насандаа сургуульдаа ирэхэд дуртай болон дургүй болгодог байсан зүйлүүдээ эргэн санахыг хүснэ.
- Дадлага цаасаа хоёр хувааж эхний хэсэгт сургуульд ирэхэд дуртай байлгадаг зүйлсийг нөгөө хэсэгт сургуульд ирүүлэхэд дургүй болгодог байсан зүйлсийн талаарх оролцогчдын саналыг цувруулан бичнэ.
- Багуудад зургаан өнгийн наадаг цаас өгч багаараа “Сургууль дах таагүй зүйлсийн



талаар ярилцан эдгээр асуудал нь сургуулийн үйл ажиллагааны ямар хүрээнд хамрагдаж байгааг тодруулан өнгийн цаасаа наана. Үүнд:

- Сургуулийн бодлого
 - Сургуулийн орчин
 - Хүний нөөц
 - Сургалтын үйл ажиллагаа
 - Эцэг, эхийн оролцоо
 - Орон нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа
- Сургагч багш оролцогчидтой хамтран сургуулийн үйл ажиллагааны ямар хүрээнд хамгийн олон асуудал байгааг гаргана. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд ямар үйл ажиллагааг зохион байгуулж болох талаар оролцогчдын санаа бодлыг сонсоно.

Тусгал: Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөрт тусгах санаанууд байгаа эсэх талаар ярилцан цаашид энэ чиглэлээр сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхэд зохион байгуулах үйл ажиллагааны жагсаалтыг гаргана.

2.2 "НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ" ХӨТӨЛБӨРИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Мэдээлэл: "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих" хөтөлбөр нь:

1. Сургуулийн бодлого
2. Сургуулийн орчин
3. Хүний нөөц
4. Сургалтын үйл ажиллагаа
5. Эцэг, эхийн оролцоо
6. Орон нутгийн байгууллагатай ажиллах хамтын ажиллагаа гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

1. "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих" сургуулийн бодлого

Хүүхэд багачууд, иргэд олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх, боловсролын тухай хуулийг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, сургуулийн дүрэм, дотоод журам зэрэг сургуулийн бүхий л баримт бичиг нь сургуулийн бодлого болно.

Сургуулийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь өргөн цар хүрээг хамрах бөгөөд дараах чиглэлүүдээр сургуулийн бодлогыг тодорхойлж болно.

- Сургууль нь нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байх.



- Сурагчдын дасан зохицох болон суралцах чадварыг дэмжихэд сургуулийн багш, ажилтнууд, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах

Сургуулийн бодлогыг хэрэгжүүлэхдээ “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” буюу цаашид (“ДЗСЧДСХ” гэх) боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Хөтөлбөрт сургуульд шинээр элсэн орж байгаа нэгдүгээр ангийн сурагчдыг сургуулийн амьдралтай богино хугацаанд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийг сургуульд элсэн суралцахаас өмнө болон суралцах явцад тэдний дасан зохицох болон суралцах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа тусгагдана. Сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрх зүйн үндэс бүрдсэн байх, зарим зохицуулалтууд хийх шаардлагатай болох тул доорхи зүйлсийг анхаараарай.

- Сургуулийн дүрэм, дотоод журам, сургууль, ангийн дэгийг хянан сайжруулж, баталгаажуулах
- Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагаанд сургуулийн удирдлагаас эхлээд нийт ажилтнууд ажил үүргийнхээ дагуу зайлшгүй оролцож, хамтран ажиллах шаардлагатай. Иймд нэгдүгээр анги даан ажиллаж байгаа багшид үзүүлэх дэмжлэг, туслалцааг сургуулийн бодлогоор дэмжих нь чухал юм. Өөрөөр хэлбэл, сургуулийн бүх ажилтнууд нэгдүгээр ангийн багш, суралцагчийг хэрхэн дэмжин хамтран ажиллах талаар үүрэг хариуцлагыг тодорхойлж түүнийг хөтөлбөр, төлөвлөлт, эрх зүйн бичиг баримтад тусган баталгаажуулсан байх нь зүйтэй.
- Сургуулийн бодлого нь бүх багш, ажилтнууд, эцэг эх, олон нийтийн нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих тухай ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх тул энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд тогтмол сургалт, үйл ажиллагаануудыг төлөвлөж зохион байгуулдаг байх нь чухал юм.

2. Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан сургуулийн болон сургалтын орчин

Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицоход сэтгэл зүйн болон материаллаг орчин бүрдсэн байх нь нэн чухал байдаг. Сэтгэлд хүрсэн сайхан харилцаа, санаанд нийцсэн тавлаг орчинд явагдаж буй үйл ажиллагаа нь чанартай, хэрэгцээг хангасан байдаг.

Сургуулийн сэтгэл зүйн орчинд үндсэн хоёр асуудлыг багтаадаг. Үүнд:

- Анги танхимд үүсэх сэтгэл зүйн таатай харилцаа
- Сургуулийн орчин дахь хүмүүс хоорондын харилцаа

Зургаан настай хүүхэд сургуульд элсэн орж, **сурах-сургах** үйл ажиллагаанд оролцох болсноор:

- Хүүхдийн амьдралд эрс өөрчлөлт гарна.
- Хүүхэд амьдралын шинэ хэв маяг, үйл ажиллагааны шинэ төрөл, нийгэм болон гэр бүлд эзлэх шинэ байр суурь, насанд хүрэгчид болон үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны шинэ хэлбэрт шилжинэ.



- Хүүхдийн үндсэн үйл ажиллагаа солигдож, тоглоомын үйл ажиллагаанаас сурах үйл ажиллагаанд шилжинэ. Сурах үйл ажиллагаа нь хүүхдийн гол хөдөлмөр болж, бүх зүйл сургууль, сургуулийн дэглэмд захирагдах болно.
- Хүүхэд багш, сургууль, эцэг, эхийнхээ өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээнэ.
- Бие бялдар болон сэтгэл хөдлөлийн ачаалал нэмэгдэнэ.
- Сургуулийн өмнөх чөлөөт байдал нь хамаарал, шинэ дүрэм горимд захирагдах харилцаагаар солигдоно. Хүүхдэд тавигдах шаардлага нэмэгдэж, хүүхэд аажмаар "юу хүсэж байна вэ?" гэдгээс илүү "юу хийх хэрэгтэй вэ?" гэсэн байр сууринд шилжинэ.
- Үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны хэв маяг өөрчлөгдөнө. Ангийн сурагчдын дунд эзлэх хүүхдийн байр суурийг тодорхойлох гол хэмжүүр нь сурлагын амжилт болж эхэлнэ. Үүний хамтаар сурагчдын хамтын үйл ажиллагаа нь хариуцлагад суурилсан харилцааны шинэ хэв маягийг бий болгоно.
- Хүүхдийн амьдрал, үйл ажиллагааны дээрх онцлогууд нь хүүхдийн сэтгэцийн бүхий л талуудад нэгэн адил илэрнэ.
- Тиймээс сурагч болж сургуулийн амьдралд хөл тавьж буй зургаан настай хүүхдийг шинэ нөхцөлд дасан зохицоход сургуулийн бүх л ажилтнууд чухал үүрэгтэй билээ.

Нэгдүгээр ангид зургаан настай хүүхдийг сургах болсноор зарим сурагч сургуулиас тавих шаардлагуудыг ханган биелүүлэхэд бэрхшээлтэй тулгардгаас тэдэнд сэтгэл зүйн хувьд таатай биш байдал үүсдэг. Иймд сургалтын үйл ажиллагаанаас үүсэх ачаалал, шаардлагыг давах чадварыг урьдчилан харсан бодлого боловсруулан ажиллах нь зүйтэй. Үүнд нэгдүгээр ангийн сурагчдын онцлогийг харгалзсан, дагаж мөрдөх боломжтой дэг журмыг боловсруулах, ойлгомжтойгоор танилцуулах зэрэг асуудлыг тусгасан байна. Сургууль, хичээлийн орчинд суралцагчдад сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд доорх зүйлүүдийг сургуулийн бүх ажилтнууд, суралцагчид даган мөрдвөл зохино. Үүнд:

- Хүүхэд бүртэй мэндлэх
- Найрсаг зан хандлагыг дэмжих
- Эерэг үг хэллэг хэрэглэн харилцах
- Хүүхэд өөрт нь хандах тохиолдолд анхааралтай сонсож, харилцах
- Ангийн дүрэм, дадал хэвшлийг сурагчдад таниулж тайлбарлах
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд дэмжин оролцох
- Ичих, эмээх нөхцөл байдлыг бууруулах
- Гаргасан алдааг нь засахын тулд хөгжилтэй, хошин байдлаар хандах

Сургуульд сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд багш, сургалтын менежер, удирдах ажилтнууд төдийгүй, сургууль, хамт олныг бүрдүүлж байгаа бүх багш, ажилтнууд нэгдүгээр ангийн сурагчидтай найрсаг харилцах, тэдний сэтгэл зүйн онцлогийг мэдэж сургуулийн орчинд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх нь чухал байдаг.

Нэгдүгээр ангийн суралцагчдад зориулан сургуулийн гаднах, доторх орчныг боломжиндоо тулгуурлан бүрдүүлэх нь чухал. Энэхүү орчныг бүрдүүлэхэд эцэг эх, олон нийтийн оролцоо дэмжлэг, сургуулийн гаднах түншлэлийг ашиглаарай.



Нэгдүгээр ангийн сурагчдын сурч хөгжих сургуулийн орчинд байвал зохих зүйлс, тэдгээрийн ач холбогдлыг доор үзүүлэв:

Сургуульд байвал зохих зүйлс	Ач холбогдол
Сургуулийн орчин дахь тэмдэг тэмдэглэгээ	Сургуулийн гадна, дотно орчинд тэмдэглэгээ байршуулснаар нэгдүгээр ангийн сурагчдад ойлгомжтой эрсдэлгүй байх боломж бүрдүүлнэ.
Нэгдүгээр ангийн сурагчдыг таних тэмдэг буюу нэрийн хуудас	Нэгдүгээр ангийн сурагч гэдэг нь хэнд ч танигдахаар тусгайлсан таних тэмдэгтэй байвал тэднийг ойлгох, дэмжих, хайрлан хүндэтгэхэд томоохон туслалцаа болно.
Сургуулийн дэг нь нэгдүгээр ангийн суралцагчдад таарч зохицсон байх	Нэгдүгээр ангийн сурагчдын насны онцлогт тохирсон, биелүүлэхэд боломжтой байх нь ая тухтай, нээлттэй байхын зэрэгцээ тодорхой дэг зохицох чадварт суралцана.
Хичээлээс гадуур хийгдэх ажлын жагсаалт, сэдэв сонголт	Сурагчдад хэдийд, ямар үйл ажиллагаа зохион байгуулагдах, хэн удирдах, ямар зорилго агуулсан зэрэг мэдээлэл ил тод байх нь дэмжлэг, оролцоог нэмэгдүүлдэг.
Номын сан нь нэгдүгээр ангийн сурагчдад үйлчлүүлэхэд тохиромжтой байх	Номтой харилцаж номын сангаар үйлчлүүлэх сонирхлыг нэмэгдүүлнэ.
Эмчийн өрөө нь нэгдүгээр ангийн сурагчид үйлчлүүлэхэд таатай байх	Эмчээс чөлөөтэй үйлчилгээ авах шаардлагатай зөвлөмж, зөвлөгөө авах боломж бүрдүүлнэ.
Нийгмийн ажилтны өрөө нь нэгдүгээр ангийн сурагчдад үйлчлүүлэхэд нээлттэй, сонирхол татахуйц байх	Суралцагчид чөлөөтэй орж, хэрэгцээтэй үйлчилгээгээ авах боломжтой болно.
Хүүхэд хүлээн авах хэсэг, өрөө	Сургуулийн үүдний хэсэгт нэгдүгээр ангийн сурагчдыг хүлээн авах хэсгийг тусгайлан бэлтгэж, тэнд сургуулийн аль нэг ажилтан сурагчдыг хүлээн авч, ангид урин оруулах нь сэтгэл зүйн эерэг орчинг бий болгоно. Хичээл эхлэхээс өмнө болон тарсны дараа эрсдэлгүй байх боломжоор хангагдана.
Хүүхдийн болон түүний гэр бүл, эцэг эхийг урьж уулзах өрөө танхим	Сурагч, эцэг, эхчүүдэд зориулсан тусгай өрөө нь тэдэнтэй ярилцах мэдээлэл туршлага солилцох, хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
Хаясан, гээгдсэн зүйлсийг хадгалах хэсэг	Нэгдүгээр ангийн сурагчид өөрийн эд зүйлсдээ бүрэн анхаарал тавьж, хямгадах чадвар сул байдаг тул эдгээрийг цуглуулж, хадгалдаг сав, шүүгээ байх хэрэгтэй байдаг. Мөн сурагчид бусдын хаяж гээгдүүлсэн зүйлд хүндэтгэлтэй хандаж сурна.
Нийтэд зориулсан, мэдээ, мэдээлэл, сурталчлах хэрэгсэл, хүүхэд хамт олны бүтээлийн сан	Сурагчийн талаар болон тэдний бүтээлийг нийтэд тогтмол сурталчилж байх нь хүүхэд өөрөөрөө, эцэг, эхчүүд хүүхдээрээ бахархах, цаашид илүү чанартай бүтээл гаргах сэдэл өгөх сайн талтай. Ялангуяа анги хамт олны бүтээлийг байрлуулах нь чухал.
Эцэг эхэд зориулсан мэдээллийн самбар	Нэгдүгээр ангийн сурагчдын хичээлийн хуваарь, хичээл тарах, орох цагийн мэдээлэл буюу хаана хичээллэж буйг нээлттэй байрлуулах, мөн тэдэнд зориулсан зөвлөмж, зарлал, санамж байрлуулна.
Ариун цэврийн өрөө, 00 нь стандартын дагуу байх	Насны онцлогт тохирсон үйлчилгээ авах.



Нэгдүгээр ангийн сурагчдын загвар ангийн сургах орчинд байвал зохистой зүйлс:

Ангийн зай талбай, сандал, ширээ, анги танхимын стандарт шаардлага, зайлшгүй иж бүрдэл, тоглоом, сургалтын арга зүйн иж бүрдэл, ариун цэврийн өрөө, ангийн зай талбай зэргийг тодорхойлсон байдаг. Тавилга, эд зүйлсэд тавигдах шаардлагыг нарийн баримтлаагүйгээс зургаан настай хүүхдийн бие, физиологийн хөгжлийн онцлогоос шалтгаалан үүсэх ясны гаж хөгжил, гэмтэл бэртэл зэрэг дараа хойчийн хор уршиг нь нөхөгдөшгүй билээ.

Нэгдүгээр ангийн сургалтын орчинд доорх шаардлагыг хангасан байх нь тохиромжтой:

Орчин	Тавигдах шаардлага
1 Анги	<ul style="list-style-type: none">- Анги дүүргэлт 25-32 сурагчтай байх¹- Нэг хүүхдэд оногдох шалны талбай 2 кв.метр- Агаар 7-10 куб.метр байх- Ангиуд багадаа 60 кв.метр талбайтай байх- Сандал, ширээ гэх мэт
2 Ангид байх тоглоомын иж бүрдлүүд	<ul style="list-style-type: none">- Эвлүүлэх, угсрах өрж байгуулах, наах,- Оньсон болон хөлөгт,- Зурагт, хөдөлгөөнт,- Хэл, яриа хөгжүүлэх,- Бие бялдрыг хөгжүүлэх,- Шатар, даам
3 Ангид байх сургалтын арга зүй, хэрэгслийн иж бүрдлүүд	<ul style="list-style-type: none">- Сурах бичиг, цагаан толгойн иж бүрдэл,- Бүтээлийн болон үзүүлэнгийн нэгдсэн сан (хэвлэмэл, зурагт, хөдөлгөөнт)- Хичээлд ашиглах хөгжим, телевизор, CD, DVD тоглуулагч, дуу, шүлгийн бичлэгтэй хуурцаг,- Зурагт үлгэр, ном, өгүүлэл бүхий номын сан,- Зурагт хуудас,- Ханын тасалгаа бүхий сурагчдын бүтээлийн самбар, тавиур,- Геометрийн дүрсүүд зэрэг сургалтад хэрэглэх техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдхүүн
4 Зургаан настай хүүхдийн сандал ширээнд тавигддаг шаардлагууд	<ul style="list-style-type: none">- Мод, модлог материал, фанер, навчит төрлийн модоор хийсэн байх,- Будгийн бэхжилт нь савантай халуун усаар, ариутгалын бодисоор угаахад ховхорч, хуурахгүй байх,- Ширээ сандал нь өнгөлөгдсөн байх- Ширээний тавцан цайвар, хөх, шаргал өнгөтэй байх,- Ширээний өндөр 560 миллиметр- Сандлын өндөр 585 миллиметр- Суудлын өргөн 300 миллиметр- Суудлын урт 330 миллиметр- Твшлэгийн өндөр 285 миллиметр- Сандлын суудал шалнаас 300 миллиметр- Самбарын доод ирмэг шалнаас 550 миллиметр
5 Бусад:	<ul style="list-style-type: none">- 1 суултуурт ноогдох хүүхдийн тоо 20 байх- Цонхны тавцан дээр цэцэг тавихгүй, хөшгөөр хааж болохгүй- Цэцгийг тусгай тавиур дээр шалнаас 650-700 миллиметр д байрлуулах- Хулдаас эсвэл паркетан шалтай байх- Ангийн температур 18-20 градус байх- Цонхны гэрэлтүүлэг сурагчдын зүүн гар талаас хангалттай тусдаг байх

1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдын "Загвар анги байгуулах тухай" №243 тушаал



ДАСГАЛ: “АНГИ”

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчдыг хүлээн авах ангийн орчин стандартад нийцсэн эсэхэд ажиглалт үнэлгээ хийж дэмжлэг үзүүлэх чадварт суралцана.

Хэрэглэгдэхүүн: Үнэлгээний хуудас, дадлага цаас, өнгийн маркер, уртын хэмжүүрийн багаж



Ажиглалтын хуудас

№	Стандартын дагуу ангид байх зүйлс	Байгаа (+) Бүрэн бус (-) Байхгүй (!)
1	Самбарын доод ирмэг шалнаас 550 миллиметр	
2	Цонхны тавцан дээр цэцэг тавихгүй, хөшгөөр хааж болохгүй	
3	Цэцгийг тусгай тавиур дээр шалнаас 650- 700 миллиметрт байрлуулах	
4	Ширээний өндөр 560 миллиметр	
5	Сандлын суудал шалнаас 300 миллиметр	
6	Хичээлд ашиглах хөгжим, телевизор, CD, DVD тоглуулагч, дуу, шүлгийн бичлэгтэй хуурцаг	
7	Ханын тасалгаа бүхий сурагчдын бүтээлийн самбар, тавиур	
8	Гар нүүрний угаалтуур	
9	Ус буцалгагч	
10	Зурагт үлгэр, ном, өгүүлэл бүхий номын сан	

Ажиллах алхам:

- Оролцогчдыг багт хуваана. Дасгалын зорилгоо танилцуулна.
- Үнэлгээний хуудсаа тараан өгч ажил үүргийн хуваарийг гаргуулна. (хэн хэмжих хэн тэмдэглэх хэн стандарттай харьцуулах гэх мэт)
- Багууд оногдсон ангидаа очиж ажиглалт судалгаа хийнэ.
- Стандартын дагуух үзүүлэлтийг харсны дараа бусад зүйлийг ажиглах, тэмдэглэх
- Сургалтын танхимд эргэн ирж багийн дүгнэлтээ гаргана.
- Багаараа хэлэлцэн орчныг сайжруулах төлөвлөгөөнд оруулах саналаа боловсруулан танилцуулна.

Тусгал: Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, амжилттай суралцахад ангийн орчин ямар байгаа талаар дүгнэлт хийх нь цаашид анхаарах асуудлуудыг тодруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад суурь мэдээлэл болно.

ДАСГАЛ: “ЦҮНХ”

Зорилго: Зургаан настай хүүхдийн эрүүл мэндийг анхаарах зорилгоор тэдний цүнхийг хэрхэн бэлтгэх талаар мэдээлэл солилцох улмаар сургуулийн мөрдөх дүрэмд, дотоод журамд тусгах

Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас, бичгийн цаас, дадлага цаас, өнгийн фломастер





Ажиллах алхам:

- Хүн бүр зургаан настай хүүхдийн цүнхэнд юу юу байдаг талаар бодно.
- Багаараа зургаан настай хүүхдийн цүнхэнд байх ёстой зүйлсийг зурж /бичиж ойролцоогоор ямар жинтэй байх талаар санал бодлоо нэгтгэнэ.
- Багууд хийсэн ажлаа танилцуулж дууссаны дараа стандарт хэм хэмжээтэй тохируулан өөрсдийн гүйцэтгэсэн ажлаа үнэлж, хэрвээ ямар нэг алдаа байвал багаараа засаж гүйцэтгэнэ.

Тусгал:

Сургагч багш дасгалын төгсгөлд дараах мэдээллийг өгөх ба эдгээр мэдээллээс сургуулийн дүрэм, дотоод журамд нэмэлтээр оруулах хэсгийн талаар ярилцан тохирно.

Нэгдүгээр ангийн сурагчдын цүнхний талаарх танилцуулга

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид цүнхэндээ сурах бичиг, дэвтэр, үзэг, харандаанаас гадна баримлын шавар, өнгийн харандаа, хайч, цавуу, үдийн цай уух аяга, таваг, халбага, тэдгээрийг ангилж хийх уут сав, биеийн тамирын хувцас зэргийг авч явдаг байна.

Манай улсын хувьд стандартчилал хэмжил зүйн газраас нэгдүгээр ангийн нэг сурах бичгийн дундаж жин 140 грамм, нийт сурах бичгийн жин 1,5 кг-аас хэтрэхгүй байхаар тооцоолон шинэчилсэн байна. Манай улсын судлаачид 6 настай эрэгтэй хүүхдийн биеийн жин дунджаар 19.2 кг, эмэгтэй хүүхдийнх дунджаар 18.8 кг байдгийг тогтоожээ. Зарим улс оронд хүүхдийн цүнхний хүндийн жин нь тухайн хүүхдийн биеийн жингийн 10-15 хувиас хэтрэхгүй байх нь зохимжтой гэж үздэг байна. Хэрвээ түүнээс илүү жинтэй бол хүүхдэд хүчилтөрөгчийн нэмэлт хэрэгцээг бий болгодог байна. Эдгээрээс үзвэл 6 настай сурагчийн цүнх 2кг-аас хэтрэхгүй жинтэй байх нь зохистой байна.

Гэвч одоогийн байдлаар нэгдүгээр ангийн нэг сурагчийн монгол хэл, математикийн сурах бичиг, бэлтгэл хөтөлбөр, хүн орчин, дүрслэх урлаг, технологи, хөгжмийн хичээлийн дасгал ажлын дэвтрүүд болон монгол хэлний хичээлийн хичээнгүй бичиг, математикийн дасгал ажлын дэвтрүүдийн нийт жин 1325г байна. Өдөр тутмын хичээлд байнга хэрэглэдэг үзэг, харандаа, дэвтэр, баримлын шавар гэх мэт хичээлийн хэрэгслүүдийн дундаж жин 2860г байна. Сурагчдын цүнхэнд байдаг дээрх зүйлсийн нийт жин 4185г байна (хүснэгт).

Сурагчид дээрх сургалтын хэрэглэгдэхүүнээс гадна тоо тоололд ашиглах ууттай шагай, савх, шоо, үсэг, үе нүдлэхэд шаардлагатай хэвлэмэл материалуудаас гадна сургалтын нэмэлт гарын авлагуудыг /ялангуяа математик, монгол хэлний хичээлд/ цүнхэндээ авч явдаг. Эдгээрийн дундаж жин ойролцоогоор 350-450г байна. 6 настай сурагчдын тоглож наадах хэрэгцээ харьцангуй илүү байдаг тул тэдний цүнхэнд хайртай тоглоом нь ч байдаг. Иймээс нэгдүгээр ангийн сурагчдын цүнхний хүндийн жин ойролцоогоор 5кг байх үндэслэлтэй байна.

Нэгдүгээр ангийн сурагчийн цүнх зохист хэмжээнээс илүү хүнд байгаа нь тэдний бие бялдарын өсөлт, хөгжилд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй цаашид нурууны өвчлөлд өртөх магадлал өндөр байдаг тул дараах зөвлөгөөний дагуу сурагчдын цүнхний хүндийн жинг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө

Хүүхдийн цүнх биед эвтэй байх нь тэдний эрүүл мэндэд маш чухал ач холбогдолтой. Учир нь хүүхдийн цүнх тэдний нуруунд төдийгүй хүзүү, мөр, гар болон биеийн бусад хэсгийн хөгжилд ихээхэн нөлөөтэй.



Хүүхдийн цүнхийг зөв сонгоход харгалзах зүйлс:

- Хэт бариу оосортой цүнх нь хүүхэд чөлөөтэй амьсгалахад саад учруулдаг.
- Цүнхний өргөн мөрөвч нь түүний жин хүүхдийн биед жигд хуваарилагдахад тусалдаг.
- Цүнхний хажуугийн халаасуудад зарим эд зүйлсийг хийх нь цүнхний жинг хүүхдийн биед жигд хуваарилагдахад тусалдаг.
- Нуруундаа үүрдэг цүнх хоёр мөрөвчнөөс гадна бүсэлхийгээр бүслэх боломжтой байвал хүүхдийн биед эвтэй байдаг.
- Цүнхэнд хийх хүнд жинтэй, хавтгай зүйлсийг хүүхдийн нурууны талд хийх нь тохиромжтой.
- Аль болох хөнгөн материалтай, эдэлгээ сайтай хичээлийн хэрэгслийг хүүхдэдээ бэлтгэж өгөх хэрэгтэй.
- Өдөр бүр хэрэгтэй хичээлд зайлшгүй хэрэгцээтэй зүйлсийг нь өгч явуулж байхад анхаарна. Ялангуяа тоглоом гэх мэт хичээлд хэрэглэхгүй зүйлсийг сургууль руу өгч явуулахгүй байх хэрэгтэй.
- Хүүхдийн цүнхний жинд байнга хяналт тавина.

Багш нарт өгөх зөвлөгөө

- Багш нар хичээлийн жилийн эхэнд эцэг, эх, хүүхдүүдэд цүнхийг эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр ашиглах талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй.
- Эцэг эхчүүдэд цүнхийг хүүхдийнхээ биед тохируулан сонгох, цүнхний жинд хяналт тавих, цүнхээ зөв үүрэхэд нь туслах талаар зөвлөгөө өгнө.
- Улирал тутамд хүүхдийнхээ цүнхний жинг багасгах талаар эцэг эхчүүдэд сануулж, зөвлөгөө өгнө.
- Аль болох хөнгөн материалтай, эдэлгээ сайтай хичээлийн хэрэгслийг хүүхдэдээ бэлтгэх талаар эцэг эхчүүдэд зөвлөнө.
- Дараагийн өдрийн хичээлд хэрэглэх хичээлийн хэрэгслийг сурагчдад заавал хэлж өгч байна. Өдөр бүр тухайн өдөр орох хичээлийн хэрэгслээ л авч явж байх талаар тогтмол зөвлөгөө өгч, хяналт тавина.
- Сурагчдад цүнхээ зөв үүрэх талаар зөвлөх, буруу үүрэх болон хэт их жинтэй цүнх үүрснээс тэдний эрүүл мэндэд учруулах хор уршгийг сайтар таниулна.
- Хэтэрхий олон нэмэлт дэвтэр хэрэглэхгүй байхад анхаарна.
- Зарим үед даалгаврын дэвтрийн оронд цаас ашиглах нь тохиромжтой.
- Хүүхдэд гэрийн даалгавар их өгөх, ялангуяа олон төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах даалгавар өгөх нь цүнхний хүндийн жинг нэмэгдүүлж байгааг анхаарах хэрэгтэй.
- Зарим үед сурах бичгийн оронд хөнгөн жинтэй өөр сургалтын хэрэглэгдэхүүн ашиглахыг хичээнэ.
- Хүүхдийн байнга хэрэглэдэггүй зарим дэвтэр, хичээлийн хэрэгслийг ангид хадгалж, хэрэгтэй үед нь гаргаж өгнө.

Сургуульд өгөх зөвлөгөө:

- Нэгдүгээр ангид үзэх сурах бичиг, дасгал ажлын дэвтрээс гадна нэмэлт гарын авлагыг өдөр тутам хэрэглэхгүй байхад анхаарна.
- Хичээлийн хуваарийг гаргахдаа хүүхдийн цүнхэнд байх материалын жинг харгалзана.



- Сурагчийн цүнхний хүндийн жинд тодорхой хугацаанд тогтмол хяналт тавьж, багш эцэг эхчүүдэд зөвлөгөө өгнө.
- Зарим үед эцэг эхчүүдээр хүүхдийн цүнхийг жинлүүлнэ. Ингэснээр эцэг эхчүүд хүүхдийнхээ цүнхний жинд анхаарал хандуулна.
- Боломжтой бол сургууль хүүхдийн хичээлийн хэрэгслийг хадгалдаг шүүгээ байлгаж болно. Үүнтэй холбоотойгоор сургууль хүүхдийн хичээлийн хэрэгслийг хадгалдаг шүүгээ савтай болохыг төлөвлөж хэрэгжүүлж болно.
- Ангид шургуулгатай ширээг сонгоно.
- Багш, эцэг, эх, хүүхдийн дунд цүнхний жинг багасгах кампанит ажил зохион байгуулж болно.
- Нэг өдөр хийх гэрийн даагаврын дээд хэмжээг тогтоож мөрдөх арга хэмжээ авна.
- Сургууль дээр зарим хичээлийн даалгаврыг хийдэг цагийн хуваарь гаргаж хэрэгжүүлж болох боломжийг хайж хэрэгжүүлнэ.
- Биеийн тамирын хичээл ордог өдрүүдэд хичээлд биеийн тамирын хувцастай ирэхийг зөвшөөрөх.

Хүснэгт: Нэгдүгээр ангийн сурагчдын цүнхний хүндийн жинг тооцоолсон байдал

Сургалтын хэрэглэгдэхүүний нэр	жин /г/	тоо	нийт жин /г/
1. Сурах бичиг, дасгал ажлын ном			
1 Бэлтгэл	90	1	90
2 Монгол хэл	360	1	360
3 Математик	335	1	335
4 Хүн орчин	105	1	105
5 Дүрслэх урлаг, технологи	120	1	120
6 Хөгжим	155	1	155
7 Дасгал ажлын дэвтэр	80	2	160
Дүн			1325
2. Бусад хэрэглэгдэхүүн			
1 Дэвтэр	40	6	240
2 Зургийн дэвтэр	65	1	65
3 Өнгийн цаас	50	1	50
4 Үзэг	15	1	15
5 Балын харандаа	5	1	5
6 Баллуур	15	1	15
7 Харандаа үзүүрлэгч	15	1	15
8 Хайч	45	1	45
9 Цавуу	20	15	300
10 Шугам	15	1	15
11 Үзгийн сав	75	1	75
12 Усан будаг	70	1	70
13 Баримлын шавар	160	1	160
14 Өнгийн харандаа/эсгий бал	120	1	120
15 Цүнх	750	1	750
16 Биеийн тамирын хувцас	300	2	600
17 Салфетка /нойтон, хуурай/	35	2	70
Дүн			2860
Цүнхний хүндийн жин			3935г

Сургууль, багш нар нэгдүгээр ангийн сурагчдын цүнхний жинг аль болох хөнгөн байлгахад анхаарч, аяга, таваг, халбага гэх мэт зарим зүйлийг сургууль дээрээ байрлуулахад анхаарна.



3. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд сургуулийн багш ажилтнуудыг чадавхжуулан, оролцоог нэмэгдүүлэх

Мэдээлэл: Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн нийт ажилтнуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх нь тэдний үүрэг, оролцоог дэмжих нэгэн арга зам мөн. Сургуульд дөнгөж элсэн орж буй сурагчдыг сургуулийн амьдралд дасан зохицох, амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлсэн үйлчилгээ нь биднээс илүү өргөн цар хүрээтэй мэдлэг, дотно харилцаа, нарийн арга ухааныг шаардах болно. Сургуулийн удирдлага болон ажилтнууд нэгдүгээр ангийн сурагчидтай хамтран ажиллаж, тэдэнд тохирсон үйлчилгээ үзүүлэхийн тулд зургаан настай сурагчдын насны онцлог, дасан зохицох чадварын талаар сургалтад хамрагдан зохих хэмжээний ойлголттой болсон байх хэрэгтэй. Иймд нэгдүгээр ангийн сурагчидтай ажиллах бүхий л хүмүүсийг нэгтгэх, нэгдсэн удирдлагаар хангах, чадавхжуулах, нээлттэй оролцуулах ажлыг сургуулийн бодлогод тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүүхдийг сургуульд элсэн орохоос өмнө болон сургуульд ормогц олон төрлийн асуулга судалгаагаар тэдний талаар мэдээлэл цуглуулдаг. Эдгээрийг зөвхөн ангийн багш нэгтгэн өөрийн ажилд ашиглан хадгалах бус харин сургуулийн удирдлага, ажилтнууд, түншлэгчид судалгааг хамтран хийдэг, тэрхүү судалгаагаа өөр өөрийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй, бодитой үр өгөөжтэй болгох зорилгоор ашигладаг болгох талаар сургуулийн зүгээс чиглэл гарган үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй.

Оролцоог нэмэгдүүлэх нэг арга зам нь эрх зүйн баримт бичгээр баталгаажуулах буюу сургуулийн дүрэм, дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан байх явдал юм. Гэвч нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагаанд сургуулийн удирдлагаас эхлээд нийт ажилтнууд өөр өөрийн ажил үүргийн дагуу зайлшгүй оролцох хэрэгтэй бөгөөд бяцхан сурагчдыг гэсэн та бүхний санал, санаачилга сургуулийн үйл ажиллагаанд томоохон дэм, тусыг үзүүлэх болно гэдгийг бүрэн ойлгосон, ухамсарласан, хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай.

Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицоход сургуулийн ажилтнуудын хийж болох ажлын чиглэл:

Сургуулийн захирал

- “ДЗСЧДСХөтөлбөр”-ийг боловсруулах үйл явц, хөтөлбөрийн хэрэгжилтид хяналт тавьж төлөвлөлт, хяналт, үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах
- Шаардлагатай зохицуулалт, зохион байгуулалт, удирдлагаар ханган манлайлах
- Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох хөтөлбөрийн хүрээнд түншлэлийг хөгжүүлэх, орон нутгийн байгууллагатай хамтарсан уулзалт зохион байгуулах
- Нэгдүгээр ангийн суралцагчдын ээлтэй орчин бүрдүүлэхэд сургууль болон бусад эх үүсвэрээс хөрөнгө зарцуулах



Сургалтын менежер

- "ДЗСЧДСХөтөлбөр"-ийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах
- Сургуульд элсэн орохын өмнөх үйл ажиллагааг харьяа хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэгтэй төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх
- Дасан зохицох чадвар сул сурагчдын судалгааг багштай хамтран гаргах, дэмжлэг үзүүлэх ажлыг сургуулийн бусад ажилтнуудтай болон эцэг эхтэй хамтран зохион байгуулах
- Дасан зохицох чадварыг дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулах, багшийн хичээл дээр суух, зөвлөгөө өгөх, сорил авах зэргээр багшийн хөгжлийг ханган ажиллах
- Эцэг эх-багштай харилцах дэвтрийн ашиглалт, үр дүнд хяналт тавин ажиллах

Сургуулийн номын санч

- Нэгдүгээр ангийн сурагчдын нас, сэтгэхүй, эцэг эх багштай харилцах дэвтэр, үзэж буй хичээл болон хичээлээс гадуурх ажлын агуулгатай уялдсан номуудаар номын санг баяжуулж ангилан сурагчдын үсэг үзэх, нүдлэх, унших зэрэг үеүүдэд сурагчид ангиудтай ажиллах хуваарь гарган ажиллах
- Хүүхэд бүрийг номтой хэрхэн нөхөрлөх талаар танилцуулга, сургалт зохион байгуулах
- Сурагчдыг номын санд хүлээн авах өдрийг зохион байгуулах
- Эцэг эхчүүдэд хүүхэдтэйгээ хамтран тэдний ном унших сонирхлыг нэмэгдүүлэх арга зүйн сургалт явуулах

Нийгмийн ажилтан

- Нэгдүгээр ангийн сурагчийн хувийн мэдээллийн **хүүхдийн хөгжил, чадварын** тухай мэдээллийг багш эцэг эхээс цуглуулж боловсруулан нэгдүгээр ангийн сурагчдад сургуулийн орчинд үзүүлэх үйлчилгээний стратеги боловсруулах, удирдах, зохион байгуулах
- Нэгдүгээр ангийн сурагчид, эцэг эхчүүдтэй тогтмол уулзах өдөр, цагтай байх
- Нэгдүгээр ангийн сурагчдын эцэг эхийн зөвлөлтэй хамтран дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах
- Хорооны нийгмийн ажилтантай хамтран судалгаа хийх, мэдээлэл солилцох, хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах

Сургуулийн эмч

- Нэгдүгээр ангийн сурагчийн хувийн мэдээллийн хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийг цуглуулан боловсруулж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллах
- Нэгдүгээр ангийн бүлэг бүрт зочилж эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх
- Өрхийн эмчтэй хамтран судалгаа хийх, мэдээлэл солилцох, хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах

Тухайн ажилтнуудтай хамтран сургуулийн бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх, сургуулийн ажилтнуудын дэмжлэг туслалцаа авах үйл ажиллагаа, дасгалын явцад харилцан ярилцаж дээрх ажлын чиглэлүүдийг тодорхойлж саналыг харгалзан ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд өөрчөлт хийх нь зүйтэй.



ДАСГАЛ: "ДАРАА НЬ ХЭН БАЙХ БОЛ"

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчид сургуулийн ажилтнуудтай танилцах үйл ажиллагааг сонирхолтой, хүртээмжтэй хэлбэрээр өрнүүлэх. Сурагчидад сургуулийн хамт олонтой дотносох, тэдэнд итгэх итгэлийг төрүүлэх.

Хэрэглэгдэхүүн: Сургуулийн том танхимд захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч, номын санч, үйлчилгээний ажилтан гэсэн 6 өртөөг зохион байгуулж бэлтгэсэн байх ба өртөө бүрийн эзэд сурагчдад өөрийгөө болон эрхэлдэг ажлынхаа талаар хялбаршуулсан, сонирхолтой мэдээллийг бэлтгэсэн байна. Ангийн багш сурагчдаа өртөө бүрт жигд тоогоор хуваарилна.



Ажиллах алхам:

- Өртөө бүр дээр өртөөний эзэд байрласан байх ба сурагчдыг орж ирэхэд хүндэтгэн хүлээж авна.
- Багш сурагчдаа хуваарилсан өртөөнүүдэд хүргэн өгснөөр танилцах үйл ажиллагаа эхэлнэ. Нэг өртөөн дээр байх хугацааг жигд тогтооно.
- "Дараа нь хэн байх бол" гэсэн дохиогоор сурагчид өртөөгөө солин цааш үргэлжлүүлж дуусгана.

Тусгал: Сурагчид удирдлага болон ажилчидтай танилцсанаар сургууль дээр олон танилтай болж, өөриймсөг хандах хандлага үүснэ.

Нэгдүгээр ангийн сурагчидтай сургуулийн удирдлагууд биечлэн уулзаж, танилцан дасан зохицох, суралцах чадварт нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тэдэнтэй ажиллах мэргэжлийн багш, бусад ажилтнуудад 6 настны онцлог, тэдэнд хандах эерэг хандлагын талаар тодорхой ойлголтыг өгч, чиглүүлэх олон талт ажлыг зохион байгуулах шаардлагатай. Үүний нэг нь мэргэжлийн багшид илгээх захидал байж болно.

..... мэргэжлийн багш танаа

Хүндэт багш танд зургаан настай бяцхан сурагчдын өмнөөс болон хувиасаа энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Багш та энэ хичээлийн жилд нэгдүгээр ангийн шинэхэн сурагчдад хичээл сургалтыг зохион байгуулахаар сонгогдсон нь танд хүлээлгэсэн итгэл, хариуцлага гэдгийг ойлгон хүлээн авсанд баярлалаа. Сургуульд шинээр элсэн орж буй зургаан настангууд нь насны болон дасан зохицохуйн нэлээд онцлогтойг анхааран судалж, өөрийн арга барилдаа тусган ажиллана гэдэгт найдаж байна. Та бүхний их үйлст амжилт хүсье.

Сургуулийн захиргаа



4. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа

Мэдээлэл: Сургуульд анх элсэн орж буй суралцагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэгдсэн аливаа үйл ажиллагаа нь сурах, сургахуйн үйлтэй холбоотойгоор явагдах нь ойлгомжтой. "Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр" нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, ялангуяа "Бэлтгэл хөтөлбөр", бага ангийн багш нарын ЗАН, эцэг, эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөтэйтэй нягт уялдаатай, тэдгээрийг дэмжсэн, хамтран ажиллахад чиглэгдсэн байна.

Нэгдүгээр ангийн сурагчийн сургуульд дасан зохицож, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь тэднийг сурагч болсных нь дараа бус, сургуульд элсэн орохоор бүртгүүлэх үе, боломжтой бол түүнээс ч өмнө эхэлбэл сургуульдаа богино хугацаанд дасан зохицож, сурах үйлдээ илүү дур сонирхолтой хандах боломжийг бүрдүүлнэ.

Нэгдүгээр ангийн багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлог байдлын талаарх судалгаан дээрээ суурилан тэдний чадвар хэрэгцээ хөгжлийн онцлогт тохирсон арга зүйгээр сургалтаа удирдан зохион байгуулах чадварт суралцсан байх талаар сургуулийн бодлогод тусган хэрэгжүүлнэ. Багш хүүхдийн дасан зохицох суралцах чадварыг хөгжүүлж үнэлэх олон арга хэлбэрүүдийг ашигладаг болсон байна.

Суралцагчийн дасан зохицох үе шатыг харгалзан дараах ажлуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Эдгээр жишээнүүд нь санал болгож буй загвар бөгөөд "Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд багшийн арга зүй, эцэг эх-багшийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор боловсруулагдсан сургалтын модулуудын агуулга, үзэл санаатай уялдуулах нь зүйтэй.

Сургуульд элсэн орохын өмнөх үйл ажиллагаа:

Сургуульд элсэн орохын өмнөх үйл ажиллагааг сурагч, эцэг эхчүүдэд хүндрэл бэрхшээлгүй харин сонирхолтой, хамтран хийх боломжтой байхаар төлөвлөх нь чухал. Сурагчдын хувьд сургуульд явах, сурах хүслийг нэмэгдүүлэх, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, эцэг, эхийн хувьд хүүхдээ сургуульд бэлтгэхэд нь тодорхой бодит дэмжлэг тусалцаа болох үйл ажиллагаа байх нь зохистой.

ДАСГАЛ: "ГОЁ ДААЛГАВАР"

Зорилго: Сургуулийн зүгээс нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж, гүйцэтгэх "Гоё даалгавар"-ыг боловсруулан хүргүүлж, сургуульд суралцах бэлтгэлийг хангуулах

Хэрэглэгдэхүүн: Дадлага ажлын цаас, өнгийн харандаа, гоё даалгаврын загвар хүснэгт





Ажиллах алхам:

- Оролцогчдыг багт хуваана.
- Багаараа сургуулийн зүгээс боловсруулан эцэг эхчүүдэд хүргүүлэх зөвлөмжийн жагсаалт гаргана. Өөрөөр хэлбэл, эцэг эхчүүдийн зүгээс хүүхдээ сургуульд элсэн ороход нь бэлтгэл болгон хийх ажлуудын жагсаалтыг гаргана.
- Үүний дараа нэгдүгээр ангид элсэн орох сурагч болон тэдний эцэг эхийн хувьд ямар даалгавар хамгийн гоё даалгавар байж болох талаар хэлэлцэн “Гоё даалгавар”-ын хүснэгтийг гүйцээн танилцуулахад бэлтгэнэ.
- Баг бүр өөр өөрийн боловсруулсан “Гоё даалгавар”-ыг танилцуулан санал солилцоно.

Тусгал: Баг бүрийн ажлыг сонсож хэлэлцсэний дараа сургагч багшийн зүгээс дараах мэдээллийг өгч сургуулийн зүгээс нэгдүгээр ангийн сурагчийг сургуульд бэлтгэх хөтөлбөрт тусгах эцэг эхэд зориулсан зөвлөмж, хүүхэдтэйгээ хамтран хийх даалгаврын загвар бэлэн болно. Даалгавар гүйцэтгэхэд анхаарах хамгийн чухал зүйл нь хүүхдийн оролцоо, санал, бодлыг тусгах явдал шүү.

Эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө дараах хувилбаруудтай байж болно.

Хувилбар 1:

Аав ээж бүхэн хүүхдээ сайн хүн болоосой, сайн суралцаасай гэж хүсдэг. Үүний тулд хүүхдийг сургуульд элсэн орохын өмнө дараах зүйлийг хийж хэвшээрэй.

- Та хүүхдээ сургуульд элсэн орох бэлтгэл болгон хүүхэдтэйгээ юу юу хийхээ төлөвлөөрэй.
- Хамтдаа өглөөний цай ууж энэ долоо хоног, энэ сар, нэгдүгээр ангид орсон жилдээ юу хийж болох талаар асууж ярилцан мартаггүйн тулд товч тэмдэглээрэй.
- Сургуульд элсэн ороход ямар нэг санаа зовж байгаа зүйл байгаа эсэхийг асууж түүнийг нь хэрхэн шийдвэрлэж болох талаар ярилцаарай.
- Сургуульд элсэн орохоос өмнө хүүхдийнхээ эрүүл мэндэд анхаарал тавьж, шүдийг заавал эмчид үзүүлээрэй. Мөн шүдээ угаах, гарын ариун цэврийн талаар зөвлөгөө өгч, ярилцаарай.
- Долоо хоногт 1-2 удаа хүүхдийнхээ дуртай тоглоомоор хамтран тоглоорой.
- Бага насных нь зургийг үзүүлж хөгжөөнтэй түүхээс нь ярьж өгөөрэй.
- Хүүхдээ зураг зурахад нь туслаарай. Тэгээд гэртээ жижиг үзэсгэлэн гаргаарай. Хүүхдийнхээ гаргасан бага ч гэсэн амжилтыг байнга урамшуулаарай.
- Хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгөх хугацаа гаргаж байгаарай. Номонд дурлах, сонирхох эхний алхам болно.
- Хүүхэдтэйгээ хамтдаа өглөөний цай, оройн хоолоо бэлтгэж, ногоо, жимс, сүү цагаан идээний ач холбогдлын талаар ярилцаарай.






Хувилбар 2:

Эцэг эхийн зүгээс нэгдүгээр ангид элсэн орох гэж буй хүүхэдтэйгээ хамтран хийх ажлын жагсаалт:

- Харандааг зөв бариулж сургах, зуруулж, будуулж сургах нь сургуулийн өмнөх чухал бэлтгэл болно. Учир нь харандаагаар зурж, будаж сурснаар үзэг барьж сурах анхны алхам болдог.
- Хүүхдэд сонирхолтой, ойр байгаа эд зүйлийг тоолуулаарай. Гэхдээ заавал зөв бурууд анхаарах биш харин сонирхлыг нь өдөөгөөрэй. Хэрвээ таны хүүхдэд сонирхолтой байвал тоог нэмэгдүүлэх, хорогдуулах дасгал хийлгэж болно.
- Өдөр бүр хүүхдэдээ 5-10 минут сонирхсон номыг нь уншиж өгөөрэй. Дараа нь номын зурган дээр ярилцахыг хичээгээрэй.
- Хүүхэдтэйгээ номын дэлгүүрээс номыг нь сонгоорой.
- Тоглоомоор нь дамжуулж өнгө, хэлбэр дүрс, том, жижиг зэрэгтэй танилцуулах, урамшуулах үйл ажиллагаа хийгээрэй.
- Хүүхдийн чадварт нь тохирсон сонирхолтой ажлуудыг даалгаарай. Аяга угаах, хувцсаа эвхэх, гутлаа үдэх, 00 өрөөнд үйлчлүүлэх гэх мэт

ЭЦЭГ ЭХ ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХАМТРАН ГҮЙЦЭТГЭЖ БОЛОХ "ГОЁ ДААЛГАВАР"

Хувилбар 1

Мартаж болзошгүй зүйлсийн жагсаалт гаргах	Бэлдсэн эсэх	Хүүхдийн оролцоо, сэтгэл ханамж ямар байсан талаар товч тэмдэглээрэй.
		
		
		
...		



Хувилбар 2:

ГОЁ ДААЛГАВАР	Гүйцэтгэл, хүүхдийн оролцоо, сэтгэл ханамж
Хүүхэдтэйгээ сургуулийн хашаагаар зугаалах, аялах, гүйх гэх мэтээр сургуулийн орчинтой танилцуулаарай.	
Хүүхэдтэйгээ мөхөөлдөс идэнгээ 1-р ангид анх элсэн орсон дурсамжаа хуваалцаарай.	
Хөршүүдийнхээ энэ жил сургуульд орох найзтай нь тоглуулаарай.	
Хичээл эхлэхээс өмнө боломжтой бол хүүхэдтэйгээ сургууль дээр ирж анги танхимаар зочлоорой.	
...	
...	

Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийг бүртгэх үеэр нэгдүгээр анги хүлээн авах багш нар, цэцэрлэгийн багштай хамтран бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг “Сургуультай танилцах” аялалд урин, сургуулийн гадаад орчинтой танилцуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулбал хүүхдийн сургуульд дасан зохицох чадварт бодитой дэмжлэг үзүүлнэ. Мөн цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн дунд эцэг, эхчүүдтэй хамтран энэхүү аяллыг зохион байгуулах хэрэгтэй.

ДАСГАЛ: “АЯЛАЛ” (СУРГУУЛЬД ЭЛСЭН ОРОХЫН ӨМНӨ)

Зорилго: Сургуульд шинээр элсэн орох гэж буй хүүхдүүдийг сургуулийн гадаад орчинтой танилцуулснаар сургуулийн талаар эерэг сэтгэгдэл төрүүлэх, сургуулийн орчинд өөрийгөө зөв авч явах, эрсдэлгүй байх зэрэг олон талын хэрэгцээг хангахад чиглэнэ.

Аяллын өмнөх бэлтгэл:

“Сургуультай танилцах” аяллыг зохион байгуулахдаа дараах бэлтгэлийг хангана.

- Аялалд оролцох хүүхдийн тоо гаргах (цэцэрлэгийн багш, хорооны нийгмийн ажилтантай хамтран)
- Цаг агаарын таатай нөхцөлийг харгалзан аяллын өдөр, цагаа товлох
- Аялал хийх газруудаа тогтоон маршрут боловсруулах
- Аяллын төлөвлөгөө гаргах
- Аяллыг удирдах багийнхан урьдчилан уулзаж, төлөвлөлттэй танилцан үүрэг, чиглэлээ тогтоох
- Аялалд оролцох хүүхдүүддээ урилга илгээх
- Аяллыг удирдан хөтлөх хүнийг томилох
- Аюулгүй байдлыг хангах





Ажиллах алхам:

- Хүүхдүүд сургууль дээр багш болон эцэг, эхчүүдтэйгээ ирнэ.
- Аяллын хөтчийн удирдлагын дагуу аялал явагдана.
- Аяллын дараа хүүдүүдтэйгээ ярилцлага хийж, сэтгэгдлийг нь яриулна.

Тусгал: Сургуулийн орчинтой танилцах аялалд оролцсоноор ирэх жил суралцах сургуулийнхаа гадна орчны ерөнхий байдал, байршил, хүүхдийн тайван байх орчин, анхаарах болон эрсдэлтэй цэгүүдтэй танилцсанаар сургуулийн орчинд тавтай, эрсдэлгүй байх чадварт суралцана.

Нэгдүгээр ангийн сурагчдад "Сургуулиа танилцуулах" үйл ажиллагаанд оролцуулахдаа сургуулийн захиргаанаас бүх хүүхдэд урилга хүргүүлнэ.

Шинэ элсэгчдээ илгээх урилга

... - ... оны хичээлийн жилд манай сургуульд шинээр элсэн суралцах болсонд талархаж, хүндэтгэлтэйгээр хүлээн авч байгаагаа илэрхийлэхийн ялдамд сургуультайгаа танилцах аялалд оролцохыг урьж байна.

Аялал ... оны ... сарын ... өдрийн ... цагт сургуулийн өмнөх талбайгаар эхэлнэ.

Сургуулийн захиргаа, хамт олон

5. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд эцэг эхийн оролцоо

Мэдээлэл: Нэгдүгээр ангид шинээр элсэн орж байгаа сурагчдын эцэг, эхчүүд сургуулийн үйл ажиллагаанд хамгийн идэвхтэй оролцдог. Эцэг эхчүүд хүүхдээ сургуульд элсэн орсон анхны үеэс л эхлэн амжилттай сайн сургахыг хичээдэг. Үүний тулд тэд хүүхдийнхээ сурах орчин, материаллаг болон хөгжлийн хэрэгцээг ойлгож мэдэхээс гадна сургууль шинэ сурагчдаа сургуульд дасгах, суралцах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ямар зорилго дэвшүүлэн, хэрхэн ажиллаж байгаагаа танилцуулж, энэ үйл ажиллагаандаа тэднийг оролцуулбал тэд илүү сайн ойлгож, хэрэгжүүлж буй бодлогод дэмжлэг үзүүлэн дуртайяа хамтран ажиллана. Сургууль, эцэг, эхчүүдтэй хамтран ажилласнаар сургуулийн бодлого, төлөвлөлт амжилттай хэрэгжин, үр дүнгээ өгдөг, сурагчдад бодитой үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлдэг орон, орны дэвшилтэт үйл ажиллагаа байсаар байгаагийн нэг нь сургуулийн Эцэг, Эхийн Холбоо/Зөвлөл юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хөгжингүй хийгээд хөгжиж буй орнуудад боловсролын тогтолцооны төрөөс хэт хамааралтай төвлөрлийг задалж, боловсролын байгууллагын өөрөө удирдах тогтолцоог дэмжсэнээр эцэг эх, олон нийт хүүхдийн боловсрол хүмүүжилд санаа тавин, сургалтын чанар, сургуулийн үйл ажиллагааг сайжруулахад оролцох, хамтран ажиллах хандлагыг барьж байна. Олон улсын




туршлагаас харахад төвлөрлийг өөрийн орны онцлогтой нийцүүлж зохистойгоор сааруулж, сургуулийн удирдлагын түвшинд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг төрийн бодлогоор дэмжиж байна. Үүний нэг томоохон илрэл нь Сургуулийн Эцэг, Эхийн Холбоо юм.

Сургуулийн Эцэг Эхийн Холбоо (СЭЭХ) нь боловсролын чанарыг улам нэмэгдүүлэхийн тулд нийт эцэг эх, асран хамгаалагч нарын хамтран ажиллах бүтэц юм.

СЭЭХ нь хүүхдийн сурч, хөгжих орчныг сайжруулах, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог дэмжих, эцэг эхчүүдийг хөгжүүлэхийн төлөө ажилладаг, эцэг эх багш, бусад сонирхогч талуудын эвлэлдэн нэгдсэн сайн дурын байгууллага юм.

СЭЭХ-ны бүтэц, үйл ажиллагааны чиглэл



СЭЭЗ-ийн үйл ажиллагааны чиглэл:

Эцэг эхийн зөвлөл нь эцэг эхийн оролцоог хөгжүүлсэн, сурагчид, эцэг эх, сургуулийн ажилтнуудыг дэмжсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь үйл ажиллагаагаа төлөвлөхдөө сургуулийн удирдлага, захиралтай зөвлөлдөж байна. Түүнчлэн Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд сургуульд холбоотой аливаа асуудлаар сургуулийн удирдлага, сургуулийн захиралд зөвлөгөө өгнө.

СЭЭЗ нь хүүхдүүдэд олгох боловсролыг чанартай, үр дүнтэй байлгахын тулд хамтын ажиллагааны олон талыг хамарч ажиллах боловч дараах 5 гол чиглэлээр үйл ажиллагаагаа зохион байгуулах боломжтой юм.

Нэгдүгээр ангийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа бусад бүлгийн ЭЭЗ-ийн үйл ажиллагаанаас зарим талаар ялгаатай байж болох учраас энэхүү зөвлөлийн зохион байгуулж болох үйл ажиллагааг доор жагсаалаа.



Үйл ажиллагааны чиглэл	Нэгдүгээр ангийн эцэг эхийн зөвлөл
1 Сургуулийн бодлого төлөвлөлтөд оролцох болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах	<ul style="list-style-type: none">- Сургуулийн бодлого, зорилго, зорилтод нэгдүгээр ангийн сурагчдын талаар санал тусгуулах- Сурагчдыг эрсдлээс хамгаалах зорилгоор орчны үйлчилгээний газарт хяналт хийж, эрх бүхий газарт санал хүргүүлэх- Суралцах чадварыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг сургуультай хамтран боловсруулж ЭЭХ-ны ажлын төлөвлөгөөнд оруулж шаардлагатай хөрөнгийг ЭЭХ-ноос гаргуулах
2 Хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none">- Нэгдүгээр ангийн танхимын стандарт хангалтад үнэлгээ хийх- Нэгдүгээр ангийн анги танхимын орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулахад оролцох- Сургалтын хэрэглэгдэхүүний баяжилтад биечлэн оролцох Эцэг, эхийг хүлээн авах өрөөтэй болох
3 Хичээлээс гадуурх үйл ажиллагааг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none">- Нэгдүгээр ангийн сурагчийн хөгжлийг дэмжсэн дугуйлан, секц зохион байгуулах- Үйл ажиллагааг урамшуулан дэмжих- Сэдэвчилсэн хичээл явуулахад хамтран ажиллах- Эрдмийн баяр, шинэ жил гэх мэт баяр ёслолд туслалцаа үзүүлэн хамтран ажиллах
4 Эцэг эхийн оролцоог хангах, идэвхжүүлэх	<ul style="list-style-type: none">- Залуу эцэг эхчүүдэд зориулсан зөвлөгөө өгөх, туршлага солилцох уулзалт хийх, урамшуулах- Эцэг эхчүүдийг сонирхлын бүлгээр нь нэг баг болгон тодорхой ажилуудыг хариуцуулах
5 Эцэг эхийн боловсролыг дээшлүүлэх буюу хүүхдэдээ хэрхэн туслах талаар эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэх,	<ul style="list-style-type: none">- Эцэг, эхчүүдийн боловсрол, ажил мэргэжлийн судалгаа гаргах- Судалгаанд суурилан сургалт, уулзалт, ярилцлага зохион байгуулах- Эцэг, эхийн боловсролд зориулсан зөвлөмж, мэдээлэл боловсруулж түгээх- Сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчдийг урьж зөвлөгөө өгүүлэх

Дээрх үйл ажиллагааг төрөл бүрийн арга, хэлбэрээр зохион байгуулж болно.

Жишээ нь: Сургуулийн удирдлага ямар нэг байдлаар нэгдүгээр ангийн сурагчдын эцэг эхтэй уулзах шаардлагатай үед тэдэнд үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс хандсан байх нь зүйтэй. Энэ нь ямар ч хэцүү асуудлыг эерэгээр шийдэх эхний алхам болно.

ДАСГАЛ: "УУЛЗАЛТАД УРИХ"

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчдын талаарх асуудлаар тэдний эцэг, эхтэй биечлэн уулзаж, зарим асуудлыг зөв зохистойгоор шийдвэрлэхэд туслах

Хэрэглэгдэхүүн: Эцэг, эхчүүдэд хандсан захидал, тав тухтай орчин, улзалтад шаардлагатай бусад зүйлс





Сайн байна уу?

Маньг нэгдтэй уулзах цаг гарган хүрэлцэн ирнэ гэдэгт итгэлтэй байна. Нэгдүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулах үйл ажиллагааг төлөвлөхөд таны санал, санаачилга үнэтэй хувь нэмэр оруулна.

Манай өрөөний №

Хугацаа: 2017.10.22-нд 15:00-16:00

Маньг хүндэтгэсэн :

Ажиллах алхам:

- Оролцогчид багт хуваагдан нэгдүгээр ангийн сурагчдын талаар эцэг, эхчүүдтэй ямар асуудлаар ярилцаж болохыг баг багтаа тодорхойлно.
- Ярилцах асуудлаа тэдэнд хэрхэн танилцуулах талаар хэлэлцэнэ.
- Үүсч болзошгүй сөрөг хандлагуудыг илрүүлнэ.
- Сөрөг хандлагыг эерэг болгон асуудлыг зөв зохистойгоор шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэнэ.

Тусгал: Хичээлийн жилийн явцад нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд эцэг, эхчүүдтэй хамтран ажиллах нэгэн хувилбартай болно.

ДАСГАЛ: “САНАЛ АВАХ ХУУДАС”

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагаанд эцэг, эхийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, зорилгоо тодорхойлох

Хэрэглэгдэхүүн: Санал авах хуудас

Хэзээ хэрэглэх: 9-р сард багтаана.

№	Аль ангийн хэний эцэг/эх	Юу хийх	Сургуулийн дэмжлэг, оролцоо юу байх
1			
2			
3			

Ажиллах алхам:

- Эцэг, эхийн санал авах хуудсыг тараан өгч, зорилгыг танилцуулна.
- Оролцогчид санал авах хуудсанд өөрсдийн дэмжлэг, үйл ажиллагааны талаар саналаа тэмдэглэнэ.
- Хуудаснууд дахь санааг нэгтгэн сургуулийн төлөвлөлтөнд орох чиглэлийг гаргана. Мөн хяналтын хуудсанд аль саналыг оруулж болохыг ярилцан тогтоно.



Тусгал: Дээрх хүснэгт сургуулийн захиргаанаас эцэг эх, эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллахдаа баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тогтооход суурь материал болгон ашиглана. Нөгөө талаар эцэг эхчүүдийн зүгээс хүүхдээ нэгдүгээр ангид элсэн орж байгаатай холбогдуулан өөртөө тодорхой зорилго тавин ажиллах хэрэгтэй гэдгийг эцэг эхийн зөвлөлөөс анхааруулах бөгөөд энэхүү зорилго нь биелэгдэх боломжтой, энгийн байх талаас нь бодолцоорой гэдгийг анхааруулан чиглүүлэх талаар ярилцаж загвар хүснэгттэй танилцана. Өөрөөр хэлбэл, сургуулийн бодлогоор нэгдүгээр ангид хүүхэд нь сурдаг эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамтран ажиллах сургуулийн чиглэл нь тодорхой болж байна гэсэн үг юм.

6. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах нь

Мэдээлэл: Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд харьяа тойргийн хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, орон нутгийн байгууллагуудтай байнгын тогтвортой түншлэлийг ханган ажиллах нь зүйтэй. Түншлэгчдийн давуу тал, нөөц боломж, санаачлага, сонирхолд түшиглэн тэдний оролцоог нэмэгдүүлэх уулзалт хийх, үйл ажиллагаагаа хамтран төлөвлөх, ажлын үр дүнгээ үнэлж, дүгнэн цаашдын ажлаа сайжруулан төлөвлөх зэргээр хамтран ажиллавал үр дүнтэй.

Сургуулиас хамтран сургах тойргийн цэцэрлэгтэй дараах чиглэлүүдээр хамтран ажиллах боломжтой.

- Цэцэрлэгээс сургуульд элсэн орох хүүхдүүдийн мэдээлэл авах
- Дараагийн шинэ хичээлийн жилд нэгдүгээр анги хүлээн авах багш нар цэцэрлэг дээр очиж бэлтгэл бүлгийн үйл ажиллагаатай танилцах
- Цэцэрлэгийн багш, хүүхдүүд нэгдүгээр ангийн хичээлд сууж үзэн, өөрийн ангийн хүүхдүүдэд сургуулийн талаар ярьж өгөх
- Сургуульд бэлтгэх үйл ажиллагааг сургууль, цэцэрлэгийн багш нар хамтран зохион байгуулах (сургуулийн танилцуулга кино үзүүлэх, бэлтгэл бүлгийн хүүхдүүд сургууль дээр зочлох, хүүхдүүд эцэг, эхчүүдтэйгээ хамтран сургуультай танилцах аялал хийх г.м)
- Нэгдүгээр ангийн сурагчид энэ хичээлийн жилд сурсан зүйлээсээ цэцэрлэгийн дүү нартаа танилцуулах

Тухайн хамтран сургах тойргийн хороо нь иргэд, өрхийн талаар илүү мэдээлэл, судалгаатай байдаг учраас хороотой нягт хамтран ажиллах нь чухал. Хороотой дараах байдлаар хамтран ажиллах боломжтой:

- Сургуульд элсэн орох хүүхдүүд болон тэдний гэр бүлийн талаар мэдээлэл авах
- Хамтарсан уулзалт үйл ажиллагааг зохион байгуулах, харилцан бие биедээ дэмжлэг үзүүлж ажиллах

Хамтран сургах тойргийн өрхийн эмнэлэгтэй хамтран ажиллах дараах чиглэлийг санал болгож байна:

- Сургуульд шинээр элсэн орж буй сурагчдын эрүүл мэндийн талаар мэдээлэл авах
- Урьдчилан сэргийлэх үзлэг хамтран зохион байгуулах
- Эрүүл мэндийн талаар эцэг эх, сурагчдад сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх



Сургуулиас хамтран сургах тойргийн бусад байгууллагатай хамтран ажиллах дараах чиглэлүүд байж болно:

- Хамтран ажиллаж шийдвэрлэх асуудлаа тодорхойлох
- Хамтран ажиллах байгууллагаа сонгох
- Нэгдүгээр ангийн сурагчид, эцэг эх, багш нарыг дэмжсэн үйл ажиллагаа зохион байгуулах
- Эцэг, эхийн боловсролыг дэмжих сургалт хийх

ДАСГАЛ: "СУРГУУЛИЙН ЗУРАГЛАЛ"

Зорилго: Сургуулийн ажилтнууд хамтран ажиллах байгууллагуудтайгаа харилцаа холбоо тогтоох, нөөц сан бүрдүүлэх, сургуулийн орчныг сайжруулах үнэлэхэд боломжит хувилбаруудтай танилцах

Хэрэглэгдэхүүн: Дадлага ажлын цаас, өнгийн харандаа, баримлын шавар, өнгийн цаас, хайч, цавуу, скоч



Ажиллах алхам:

- Оролцогчдыг багт хуваана
- Багаараа сургуулийнхаа гадаад орчны зураглалыг гаргана
- Сургуулийн түншлэлийн үйл ажиллагаа, бодит байдалд үнэлгээ хийж, хамтран ажиллах чиглэлүүдээ тогтооно
- Аль нэг байгууллага, хувь хүмүүсийг хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэх объектоор сонгоно
- Тухайн байгууллага дээр очсоны дараа сургуулийн болон багийн зүгээс ямар үйлчилгээ үзүүлж болохыг ярилцана
- Гэрээний загвараа гаргана
- Хийгдсэн гэрээний агуулгад түшиглэн төлөвлөлтөнд оруулах санаагаа олж харна

Тусгал: Хамтран ажиллах хувь хүн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, харилцан үйлчилгээ үзүүлэх талаар олон санаанууд гарна. Үүнийг сургуулийн хөтөлбөр, төлөвлөлтөнд тусгана.



3 "НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Зорилго: Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөрийг боловсруулахад сургуулийн удирдлага, ажилтнуудын болон орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, хөтөлбөрийн хяналт үнэлгээг хэрхэн бодитой хийх талаар тодорхой ойлголттой болно.

Хүрэх үр дүн: Хамтрагч бүх талуудын оролцоотойгоор нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлага, ажилтнууд, орон нутгийн хамтрагчид тус бүрийн оролцоо тодорхой болохын зэрэгцээ сургуулийн төлөвлөлтийг хянах, үнэлэх аргачлалтай болно.

Хэрэглэгдэхүүн: Багаар ажиллах хүснэгтүүд болон дадлага ажлын явцад хэрэглэх хэрэглэгдэхүүнүүдийг бэлтгэнэ.

Арга зүй: Оролцоонд суурилсан, онол, дадлагыг хослуулсан, хамтын сургалтын зарчмаар ажиллана.

3.1 СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, БАГШ, АЖИЛТНУУД, ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ НЬ

Мэдээлэл: "Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөр"-ийг боловсруулахдаа сургуулийн нийт ажилтнууд, хамтрагчдад хөтөлбөрийн тухай ойлголтыг өгч, хөтөлбөрийг боловсруулахад тэдний санал, дэмжлэгийг авах нь зүйтэй. Дараах хүснэгтүүдэд сургуулийн хөтөлбөр боловсруулахад хийгдэх үйл ажиллагаа, ашиглах материалуудын загварыг танилцууллаа.

Хүснэгт 1: Сургуулийн хөтөлбөр боловсруулахад хийгдэх үйл ажиллагаанаас

#	Зохион байгуулах үйл ажиллагаа	Оролцогчид	Ашиглах материал	Хүрэх үр дүн
1	Сургуулийн багш ажилтнууд, хамтрагчдад хөтөлбөрийн үзэл санааг танилцуулах сургалт зохион байгуулах	Сургуулийн удирдлагууд Үйлчилгээний ажилтнууд Бага ангийн багш нар Мэргэжлийн багш нар	Сургалтын модуль	Сургуулийн ажилтнууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагатай болсон байна.
2	Нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих сургуулийн бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх	Сургуулийн зөвлөлийн төлөөлөл Эцэг, эхийн зөвлөлийн төлөөлөл Сургуулийн сургагч багш нар Өрхийн эмнэлэг Цэцэрлэг Хорооны төлөөлөл	Хүснэгт 2,3,4 Сургуулийн зураглал дасгал	Сургуулийн зорилго, дүрэм, дотоод журам ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, сургуулийн дэгүүдэд дүн шинжилгээ хийгдэж цаашид сайжруулах, өөрчлөх төлөвлөгөөнд тусгах шаардлагатай зүйлс тодорхой болсон байна.



3	Хамран сургах тойргийн төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулах	Тойргийн цэцэрлэгийн удирдлага, багш нар Хорооны нийгмийн ажилтан Өрхийн эмнэлгийн эмч	Хамтрагч байгууллагатай төлөвлөлт хийх уулзалтын хөтөч	Хамтын ажиллагааны нөхцөл байдал тодорхой болж, хамтарсан төлөвлөлттэй болсон байна.
---	--	--	--	--

Хүснэгт 2: Сургуулийн дүрэм, дотоод журам бусад баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх хуудас

№	Одоо хэрэгжүүлж буй эрх зүйн баримт	1-р ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжиж буй эсэх	Ямар нэмэлт өөрчлөлт хийх
1	Сургуулийн дүрэм		
2	Сургуулийн дотоод журам		
3	Сурагч бүртгэх, хүлээн авах журам		
4	Анги, танхимд мөрдөх дэг		
3		

Хүснэгт 3: Сургуулийн ажилтнуудын оролцоонд дүн шинжилгээ хийх хуудас

2	Эрхэлсэн ажил	1-р ангийн суралцагчийг дэмжих үйл ажиллагаанд оролцож байгаа байдал	Ямар өөрчлөлт,зохион байгуулалт хийж болох	Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заалт нэмэх эсэх
	➤ Захирал			
	➤ Сургалтын менежер			
	➤ Номын санч			
	➤ Нийгмийн ажилтан			
	➤ Эмч			
	➤ Бага ангийн багш			
	➤ Мэргэжлийн багш			
	➤ Бусад ажилтнууд			
			

- Өөрчлөлтийг оруулахдаа сургалтын модулийн санаануудыг ашиглаж болно.

Хүснэгт 4: Сургуулийн гадна, дотно орчинд дүн шинжилгээ хийх хуудас

№	Үнэлэх үзүүлэлтүүд	1-р ангийн сурагчдад ойлгомжтой, тохиромжтой эсэх	Шинэчлэх/Шинээр хийх	Нэмэлт тэмдэглэл
1	Гадна орчны таних болон анхааруулах тэмдэг			
2	Сургуулийн гадна талбайн аюулгүй байдал			
3	Сургуулийн үүдний хэсэг (хүлээн авах булан)			
4	Орчны зам, гарцын тэмдэг			



- 5 Дотно орчны таних болон анхааруулах тэмдэг
- 6 Нийгмийн ажилтны өрөө
- 7 Эмчийн өрөө
- 8 Номын сан
- 9 Биеийн тамирын заал
- 10 Урлаг танхим
- 11 Угаалтуур
- 12 Суултуур
- 13

Хамтрагч байгууллагатай төлөвлөлт хийх уулзалтын хөтөч

Энэхүү хөтөч нь төлөвлөгөө хийх 5 үе шатанд таныг хөтөлж чиглүүлэх болно. Доорх хүснэгтүүдийг багийн үйл ажиллагаандаа ашиглахыг зөвлөж байна. Багийн бүрдүүлэхдээ хамтрагч байгууллага тус бүрээр байгуулан тухайн байгууллагатай хамтран ажиллах сургуулийн ажилтныг томилон бусад ажилтнуудыг жигд хуваарилах хэрэгтэй.

Алхам 1.

Эрхэм зорилгоо томъёолох: "Өөрийн орон нутгийн хүүхдүүдийн төлөө бид юу хийхийг хүсч байна вэ?" Өөр өөрсдийн зорилгыг ярилцан, нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлэн байлгах чиглэлээр өөрсдийн хариуцсан ажил, мэргэжлийн хүрэн дэх зорилгоо нэгтгэн нэг зорилготой болох нь чухал.

Алхам 2.

Одоогийн нөхцөл байдлаа үнэлэх. Багаар ажиллан харилцан ярилцаж доорх хүснэгтийн дагуу мэдээллээ цуглуулна.

Хүснэгт 1.

№	Хамтрагч байгууллага	Хамтын ажиллагааны нөхцөл байдал	Шалтгаан, бэрхшээл	Боломж, нөөц	Давуу тал	Сул тал
1	Хороо					
2	Өрхийн эмнэлэг					
3	Цэцэрлэг					
4	Бусад					

Алхам 3.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх. Мэдээллийг цуглуулж бэлтгэсний дараа асуултын дагуу ярилцана. Үүнд:

1. Өнөөгийн нөхцөл байдлыг яаж өөрчлөх вэ?
2. Шалтгаан, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх вэ?
3. Боломж, нөөцөө хэрхэн ашиглах вэ?
4. Давуу талаа яаж ашиглах вэ?
5. Сул талаа яаж сайжруулах вэ?

Алхам 4.

Төлөвлөгөө боловсруулах. Үнэлгээгээр тогтоогдсон шалтгаан, бэрхшээл, боломж, нөөц, давуу болон сул талд анхаарлаа төвлөрүүлж хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.



Энэхүү уулзалтаар тохиролцон төлөвлөсөн үйл ажиллагааг “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-т тусгах, хэрэв хөтөлбөр нэгэнт батлагдан хэрэгжиж эхэлсэн бол хөтөлбөрийн хавсралт болгон хэрэгжүүлбэл зүйтэй

3.2 “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРГУУЛЬД ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ

Ийнхүү та бүхэн “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-ийг боловсруулахад хэрэгцээтэй бүх мэдээллийг цуглуулж, шаардлагатай алхмуудыг хийлээ. Цуглуулж, боловсруулсан мэдээлэл, аргачлалаа үйл ажиллагаа болгон сургуулийн хөтөлбөр боловсруулахад бэлэн боллоо.

“Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих” сургуулийн хөтөлбөрийг боловсруулж, төлөвлөлтийг хийхдээ:

1. Сургуулийн өнөөгийн байдлын үнэлгээг ашиглах. Энэхүү үнэлгээг ашиглан бүлэг тус бүр дэх хэрэгжихгүй буюу дутмаг хэрэгжиж байгаа үзүүлэлтийг бүрэн хангалттай буюу (+) болгон түвшинг ахиулах үйл ажиллагаа төлөвлөх
2. Сургалтын явц дахь дасгалуудын үр дүн, тусгалыг төлөвлөгөөнд тусгах
3. Бүлэг гуравт байгаа дадлага ажлуудын үндсэн дээр гарсан сургуулийн баримт бичиг, орчин, хамтрагчдын хамтын ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, эцэг эх, сургуулийн бусад ажилтнуудаас гаргасан санал санаачлагуудыг тусгах

Сургуулийн хөтөлбөрийн төслийг сургуулийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн багийнхан хамтран хийвэл тохиромжтой. Төлөвлөлтийг жилийн, дунд хугацааны гэсэн чиглэлээр хийж болох бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн дүрэм, дотоод журамд хийх өөрчлөлтийг зайлшгүй тусгах хэрэгтэй. Тухайлбал:

- Сургуулийн орчинд сурагчдын мөрдөх дэгийг нэгдүгээр ангийнханд зориулан тусгайлан боловсруулах шаардлагатай. Учир нь сургуулийн дэг бол тэдний хувьд шинэ зүйл, бусад сурагчдын хувьд хэрэгжүүлж хэвшсэн зүйл.
- “Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд сургуулийн нийт ажилтнуудын үүрэг, оролцоо нэмэгдэж, ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт орох тул үүнтэй холбогдуулан сургуулийн дүрэм, дотоод журам болон бусад дэг, журмуудад зохих хэмжээний өөрчлөлтүүд орох хэрэгцээ үүсэх бөгөөд энэ өөрчлөлтийг хамтран боловсруулна.
- Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөрийг сургуулийн бусад бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай боловсруулна. Хөтөлбөр нь төсөл хэрэгжих эхний 1-2 жилд тусдаа боловсруулагдан, төлөвлөгдөж болох ч жил бүр тусад нь боловсруулан хэрэгжүүлэх бус сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон сургуулийн стратеги, дунд урт хугацааны бодлого, төлөвлөлтөнд тусган хөтөлбөрийн тогтвортой, үр дүнтэй байдлыг ханган ажиллах нь зүйтэй.

Санал болгож буй “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” нь сургуулийн нөхцөл байдлын үнэлгээний түвшингүүдийн шалгуурыг хангах зорилгоор, ерөнхийлөн тоймлон боловсруулсан учир сургууль тус бүр өөрийн онцлог, үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах нь зүйтэй.



Хүснэгт 1: Сургуулийн хөтөлбөрийн ерөнхий чиглэл, үйл ажиллагаа

№	Чиглэл	Үйл ажиллагаа
Сургуулийн бодлого		
1	Сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн эрх зүйн баримт бичгүүдэд нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, мөрдөх 2. Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1-р ангийн сурагчдын ДЗСЧД үйл ажиллагаануудыг тусгах 3. ДЗСЧДХ-ийн үйл ажиллагаанд сургуулийн төсвөөс 0.1-..%-ийг зарцуулах 4. Сургуулийн сургалтын хөтөлбөрт 1-р ангийн сурагчдын төлөвшил, суралцах чадварын шалгуур бүхий агуулга оруулах 5. ДЗСЧДХөтөлбөрийн үзэл санаа, холбогдох сургалтуудыг сургуулийн багш, ажилтнууд, хамтрагч байгууллагуудын ажилтнуудад зориулж зохион байгуулах 6. ДЗСЧДХ-ийн биелэлтийг хагас жил тутамд хянах, үнэлэх 7. ...
2	Сурагчдыг сургуульд элсэхэд бэлтгэх, сургуулийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах	<ol style="list-style-type: none"> 1. Эцэг эх, хүүхдүүдэд зориулсан сургуулийн гарын авлага, зөвлөмж боловсруулан тараах 2. Сургууль танилцуулах үйл ажиллагаа зохион байгуулах 3. Нэгдүгээр ангийн сурагчдын хичээлийн шинэ жилийн нээлт 4. Сурагчдын бүртгэл хийх хамтарсан уулзалт, мэдээлэл солилцох 5. ...
Сургуулийн орчин		
1	Сургуулийн орчинд нэгдүгээр ангийн сурагчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан орчиныг бий болгон ажиллах	<ol style="list-style-type: none"> 1. 6 настны онцлогт тохирсон "ЕБС-ийн I-II ангийн орчны загвар" батлах тухай БСШУ-ны сайдын 243-р тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах 2. Сургуулийн гадна, дотор орчинд аюулгүй эрсдэлгүй байдлыг ханган, нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан булан, хэсэг байгуулж тэмдэг тэмдэглээг байршуулах 3. Сургуулийн орчинд нэгдүгээр ангийн сурагчдад хандсан найрсаг үйчилгээ, харилцааг төлөвшүүлэн хангаж ажиллах 4. ...
Хүний нөөц		
1	Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцох сургуулийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн номын санч /номын хуваарь../, эмч /цүнх, эрүүл мэндийн судалгаа, нийгмийн ажилтан /судалгаа/ зэрэг ажилтнуудын оролцоог дэмжин, хамтран ажиллах 2. ...
Сургалтын үйл ажиллагаа		
1	Сургалтын үйл ажиллагаа нь сурагчдын дасан зохицох, суралцах чадвар, цэцэрлэгт хамрагдсан байдал зэрэг ялгаатай байдлыг харгалзан дэмжиж ажиллах	<ol style="list-style-type: none"> 1. Бэлтгэл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх 2. Хувь хүүхдийн мэдээлэл цуглуулах ашиглах арга зүй сургалт зохион байгуулж арга зүйг сургалтын үйл ажиллагаанд ашиглах 3. Эцэг эх багштай ажиллах арга зүйн сургалт зохион байгуулж арга зүйг сургалтын үйл ажиллагаанд ашиглах 4. Нэгдүгээр ангийн багш нарын хичээлд суух, зөвлөгөө өгөх, сорил авах ажлуудыг зохион байгуулах 5. ...
Эцэг эхийн хамтын ажиллагаа		
1	Сургууль, сургуулийн, ангийн эцэг эхийн зөвлөлийн нэгдүгээр ангийн сурагчдын сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хамтын үйл ажиллагааг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох чадварыг дэмжих үйл ажиллагаа төлөвлөн зохион байгуулах 2. Нэгдүгээр ангийн эцэг эхийн зөвлөлийн ажлыг дэмжин, ажиллах боломжоор хангах 3. Нэгдүгээр ангийн сурагчдын эцэг эхэд чиглэсэн зөвлөмж, сургалтуудыг зохион байгуулах 4. Нэгдүгээр ангийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд тусгагдсан бусад ажлуудыг зохион байгуулах 5. ...



Орон нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа

1	Сургууль, харьяа тойргийн байгууллагуудын нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах/ сайжруулах	1. Харьяа тойргийн цэцэрлэг, өрхийн эмэлэг, хороотой хамтын ажиллагааны уулзалт хагас жил тутам зохион байгуулах 2. Цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, 5-р ангийн багш нарын уулзалт зохион байгуулах 3. Цэцэрлэг, хороотой элсэн суралцах сурагчдын мэдээлэл солилцох 4. Өрхийн эмнэлэгтэй хамтран үзлэг, эмчилгээ зэрэг шаардлагатай ажлуудыг зохион байгуулах... 5. Хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бусад ажлуудыг зохион байгуулах 6. ...
---	---	---

Хүснэгт: 2 “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-ийн загвар

№	Чиглэл	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн	Нотлох баримт
Сургуулийн бодлого						
1	Сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх	1. Сургуулийн эрх зүйн баримт бичгүүдэд нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, мөрдөх 2.....	IX, 2017	Сургуулийн удирдлага, бага ангийн сургалтын менежер	СДЗСЧД сургуулийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.	Сургуулийн дүрэм, дотоод журам, АБТ, хөдөлмөрийн гэрээ, сургалтын хөтөлбөр, эцэг эх олон нийттэй ажиллах гэрээ, дүрэм, ангийн дэг
